

# **СОЁЛЫН ӨВИЙН ТӨВ**

**ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ  
2010 ОНЫ БИЕЛЭЛТИЙН  
ТАЙЛАН**

**СОЁЛЫН ӨВИЙН ТӨВИЙН 2010 ОНЫ БҮТЭЭГДЭХҮҮН  
НИЙЛҮҮЛЭЛТИЙГ  
ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ  
2010 ОН**

**Соёлын өвийн төвийн 2010 оны бүтээгдэхүүн  
нийлүүлэх үр дүнгийн гэрээний үйл  
ажиллагааны тайлан**

**ТУСГАЙ ЗАХИАЛГАТ БҮТЭЭГДЭХҮҮН**

**1. Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Булган, Өвөрхангай аймгийн нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг тоолж бүртгэсэн ажлын тухай:**

Монгол Улсын Сангийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайдын 2006 оны 09-р сарын 27-ны өдрийн 299/324/111 тоот хамтарсан тушаалаар “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл болох булш, хиргисүүр, хадны зураг, бичээс, хөшөө чулуу, сүм хийд, түүний үлдэгдэл, эртний хотын туурь, түүхт овоо, суврага зэргийг бүртгэх тоолох” ажлын хүрээнд 2010 оны 5 дугаар сарын 27-наас 8 дугаар сарын 1-ныг хүртэл хугацаанд Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул, Булган аймгийн үл хөдлөх дурсгал, 8 дугаар сарын 30-наас 10 дугаар сарын 12-ныг хүртэл Булган аймгийн 5 сум, Өвөрхангай аймгийн 10 сумын нутаг дэвсгэр дэх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл тооллогын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Дээрх аймгуудын нутаг дэвсгэрийг хамарсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэх, тоолох ажлыг СБӨХХэлтсийн мэргэжилтэн Б.Даваацэрэн, видео техникч П.Чинбат, сэргээн засварлагч-зураач Г.Мөнгөнцоож нарын бүрэлдэхүүнтэй баг тухайн аймгийн музей, соёлын өв хариуцсан мэргэжилтнүүдтэй хамтран ажилласан.

Хээрийн шинжилгээний баг дээрх 5 аймгийн нутагт нийт 22000 орчим км зам туулан 587 орчим дурсгалт газрын 7500 орчим ширхэг дурсгалыг бүртгэн баримтжуулж, 28000 орчим гэрэл зураг, 942 кадр зураг, 737 минутын дүрс бичлэг, 91 гар зураг зурж хэрэглэгдэхүүн цуглуулав. Дээрх судалгааны ажлын эцсийн тоо баримт гараагүй байгаа бөгөөд дэлгэрэнгүй тайлан бичигдэж байна.

Мөн 2010 оны ажлын гүйцэтгэлийн үр дүн, бүртгэл, тооллогод хамрагдсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудыг багтаасан “Монгол нутаг дахь үл хөдлөх дурсгал” цуврал каталогийг ирэх жилүүдэд хэвлүүлэх юм.

“Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл болох булш, хиргисүүр, хадны зураг, бичээс, хөшөө чулуу, сүм хийд, түүний үлдэгдэл, эртний хотын туурь, түүхт овоо, суврага зэргийг бүртгэх тоолох” энэхүү ажил нь 2010 оны байдлаар нийт 9 аймгийн газар нутгийг хамарсан байна. Нарийвчилсан мэдээллийг хүснэгтээр хавсаргав.

**БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АНГИ- 1. СОЁЛЫН БИЕТ ӨВИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ**

**1.1 Музейн үзмэрийн бүртгэлийн програмж хангамжийг шинэчлэн сайжруулах:**

Соёлын өвийн төв, “Сайбер-Андромеда” ХХК-тай музейн үзмэрийн бүртгэлийн RCN програмыг сайжруулах талаар байгуулсан 091202 тоот гэрээнд заасны дагуу 2010 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр програм хангамжийн шинэчилсэн хувилбарыг эхний байдлаар хүлээн авсан.

“Соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр”-ийн хүрээнд зохиогдсон соёлын өвийн бүртгэлийн RCN програмыг 2007 онд улс, аймгийн 36 байгууллагад суурилуулсан бөгөөд өнөөдрийг хүртэл ашиглаж байна. Ашиглалтын

явцад програмыг шинэчлэн сайжруулах, бүртгэлийн мэдээллийг серверт шилжүүлэн хадгалах шаардлага гарсан юм. Програмын сайжруулалтыг хийхийн тулд музейнүүдээс програм дээр гарч буй хүндрэл, цаашид сайжруулбал зохих шинэчлэлтийн талаар асуулга авсан. Албан бичиг болон интернэт хаягаар 10 гаруй саналууд ирсэн. Үүнд голчлон:

- Програмд зураг оруулахад заримдаа алдаа гардаг,
- Уг бүртгэлийн програм нь цуглуулгын ангилал, төрөл зүйл болон он цагийн сонголт нь ерөнхий,
- Үзмэрийн хувийн дугаар давтагдах эрсдлийг тооцоогүй учир нэг үзмэрийг олон дахин бүртгэх боломжтой,
- Музейн нэг ажилтны бичсэн бүртгэлийг өөр нэг ажилтан өөрчлөх боломжтой байдаг зэрэг санал хүсэлтүүд ирсэн.

Музейнүүдээс ирүүлсэн дээрх санал хүсэлт дээр тулгуурлан шинэ бүртгэлийн програмд дараах гол сайжруулалт болон нэмэлт өөрчлөлтүүдийг хийсэн. Үүнд:

- Бүртгэл болон өндөр нягтрал бүхий зургийг интернэт датацентр-д байрлуулсан Соёлын өвийн төвийн өндөр хүчин чадал бүхий сервер-д хадгалдаг болсон. Ингэснээр мэдээлэл дамжуулах хурд болон нууцлал нэмэгдсэн.
- Хайлтыг илүү дэлгэрэнгүй, хурдан болгосон.
- Төрөл бүрийн тайланг автоматаар гарган авах боломжтой болсон.
- RCH програмд гэрэл зураг оруулан хадгалах функцийг илүү боловсронгуй болгож өмнөх хувилбар дээр илүү их гардаг байсан зураг оруулах үеийн алдааг зассан.
- Програм өөрийн шинэчлэлтийг интернэтээс автоматаар татан авч өөрийгөө шинэчлэх боломжтой болсон.
- Нэг хэрэглэгчийн бичсэн бүртгэлийг өөрч хэрэглэгч засах боломжгүй зөвхөн үзэх боломжтой болсон.
- Үзмэрийн хувийн дугаар давхардах буюу нэг үзмэрийг олон дахин бүртгэх эрсдлийг үгүй болгосон.
- Үзмэрийг хийсэн, бүтээсэн тухай “Он цаг”-ийн сонголтыг дэлгэрэнгүй болгосон.
- Ангилал болон төрөл зүйлийн сонголтыг уян хатан болгож, тухайн шинэчлэгдсэн сонголтууд програмын автомат сайжруулалтаар дамжин музейнүүдийн програмд суугдах боломжтой болсон.

Энэхүү соёлын өвийг бүртгэх “RCH 2.0” шинэчлсэн програмын хувилбарыг 2010 оны 10-р сарын 25-27-ны өдрүүдэд болсон “Музейн бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх нь” сургалт семинарын үеэр улс, аймгийн 38 музейн бүртгэл-мэдээллийн сангийн компьютерийн процессорт суурилууллаа.

Энэ онд шинээр байгуулагдаж байгаа Өвөрхангай аймгийн Хархорин суман дахь “Хархорум” музей, Архангай аймгийн Хашаат суман дахь Хөшөө цайдамын музей, Дорноговь аймгийн музейгээс бие даан тусгаарлан хувийн музей болсон Данзанравжаагийн музей зэрэг байгуулагуудын хүсэлтийн дагуу соёлын өвийн улсын нэгдсэн сүлжээнд хамруулахаар код дугаар өгч, бүртгэлийн програм суурилуулах бэлтгэл хийгдэж байна.

## **1.2 Шинэчилсэн програм хангамж болон музейн үзмэр, соёлын биет бус өвийн БМСангийн бүртгэн баримтжуулалтын талаар сургалт зохион байгуулах:**

Соёлын өвийн улсын бүртгэл-мэдээллийн сан (БМС)-гийн тогтолцооны анхан

шатны нэгж болох соёлын өвийг хадгалж буй байгууллага дахь бүртгэл-мэдээллийн сангийн үйл ажиллагааг сайжруулах, соёлын өвийг бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэхэд мэргэжил арга зүйгээр хангаж, музейн ажилтан, бүртгэл-мэдээллийн санч нарыг мэргэшүүлэхэд “Соёлын өвийн бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх нь” сургалт семинарыг 2010 оны 10 дугаар сарын 25-27 ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгууллаа.

Сургалтанд 36 байгууллага оролцохоор төлөвлөснөөс улсын болон 21 аймгийн музей, зарим эрдэм шинжилгээний байгууллага, Үндэсний номын сан, Гандантэгчинлэн хийд зэрэг 40 байгууллагын 47 бүртгэл-мэдээллийн санч, эрдэм шинжилгээний ажилтнууд оролцсон.

Энэ удаагийн сургалтанд шинээр байгуулагдаж байгаа Өвөрхангай аймгийн “Хархорум” музей, Улсын хилийн цэргийн харъяа Улсын хилийн музей, МАХН-ын дэргэдэх Тусгаар тогтнолын музей, Дорноговь аймгийн музейгээс бие даан тусгаарласан Данзанравжаагийн музей зэрэг байгууллагууд соёлын өвийн бүртгэл-мэдээллийн улсын сүлжээнд хамрагдах хүсэлт гарган, ажилтнуудаа нэмж хамруулсан юм.

Сургалт-семинарын бэлтгэлийг хангаж хичээлийн төлөвлөгөө боловсруулан, бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэхэд мэргэжил арга зүйн гарын авлага материалыг урьдчилан бэлтгэж, хэвлүүлж музейн ажилтнуудын ажлын хэрэгцээнд зориулан тараав. Мөн музейн үзмэрийг бүртгэх “RCH буюу Registration of Cultural Heritage 2.0” програмын шинэчилсэн хувилбарыг танилцуулан, музейнүүдэд тараан суурилуулсан.

Бүртгэл-мэдээллийн сангийн үйл ажиллагааны нэг гол чиглэл нь соёлын өвийг бүртгэх, уг санд бүртгэгдсэн цаасан суурьтай болон цахим хэлбэрийн бүртгэл, мэдээллийг найдвартай архивлан хадгалж, мэдээллийн сан бүрдүүлэх явдал юм. Соёлын өвийг бүртгэлийн шинэчилсэн RCH 2.0 хувилбар, музейн үзмэр, утга соёлын өв, түүх соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэх тухай, бүртгэл-мэдээллийн сангийн үйл ажиллагааг сайжруулахад арга зүйн зөвлөмжөөр хангаж, бүртгэл-мэдээллийн санч нарыг мэргэшүүлэхэд сургалтын агуулга чиглэгдсэн.

Соёлын биет болон биет бус өвийг бүртгэх, мэдээлийн сан бүрдүүлэх арга зүйн хичээлүүдийг Соёлын өвийн төв, Монголын Үндэсний музейн мэргэжилтэнгүүд удирдан заалаа. Сүүлийн жилүүдэд аймгийн музейн бүртгэл-мэдээллийн санг түшиглэн аймгийн бүртгэл-мэдээллийн сангуудыг төвлөрүүлэн ажиллуулж байна. Аймгийн бүртгэл-мэдээллийн сан нь орон нутгийнхаа нутаг дэвсгэр дэх түүх, соёлын хөдлөх (музейн үзмэр) болон үл хөдлөх дурсгал, утга соёлын өвийг бүртгэх, мэдээллийн санг бүрдүүлэхэд энэхүү сургалт чухал ач холбогдолтой юм.

Сургалтанд оролцогчид соёлын өвийг бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэхэд тулгамдаж байгаа асуудлын талаар санал солилцон ярилцлаа. Ялангуяа хөдөө орон нутагт дээр дурдсан гурван төрлийн соёлын өвийг бүртгэхэд аймгийн бүртгэл-мэдээллийн санг өргөжүүлж, хүн хүч, техник тоног төхөөрөмж, санхүүгаар хангах, соёлын өвийн судалгаа шинжилгээний ажлыг хөгжүүлэх, музейд шаардлагатай байгаа эрдэм шинжилгээний ажилтныг ажиллуулахад төсөв хөрөнгөөр хангах, музейн ажилтнуудыг мэргэшүүлэх арга хэмжээг бодлогоор хэрэгжүүлэхийг эрх бүхий байгууллагад уламжиллаа.

Сургалтын төсвийн дагуу оролцогчдыг үдийн хоол, хөдөө орон нутгийнхнийг байраар хангасан. (Ажлын дэлгэрэнгүй тайлан Соёлын өвийн төвд хадгалагдаж байгаа)

Сургалтаар соёлын биет бус өвийг бүс нутаг, аймагт бүртгэн баримтжуулахтай холбоотой зарим мэдээлэл, арга зүйн тухай мэдээллийг музейн ажилтнуудад өгөв.

**1.3 Улс, аймгийн музейгээс бүртгэн баримтжуулсан үзмэрийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, хэрэглэгдэхүүнийг графикийн дагуу хүлээн авч, дижитал мэдээллийн сан бүрдүүлэх:**

Соёлын өвийн УНБМСанд графикт заасны дагуу улс, аймгийн музей, зарим номын сан, эрдэм шинжилгээний хүрээлэн зэрэг 36 байгууллагаас интернет сүлжээгээр дамжуулан музейн үзмэрийг бүртгэн баримтжуулсан бүртгэл мэдээллийг хүлээн авч ажиллалаа.

Энэ жил соёлын өвийг бүртгэх компьютерийн “RCH” бүртгэлийн програмыг шинэчлэн сайжруулах ажил хийгдэж байгаатай холбогдуулан музейгээс бүртгэлийг хүлээж авах ажил түр хойшлогдсон юм. 2010 оны 12 дугаар сарын байдлаар нийт музейгээс 11446 үзмэрийн бүртгэлийг хүлээн авсан ба бүртгэлийн програмын дагуу УНБМСанд нийтдээ 26438 үзмэр бүртгэгдсэн байна.

Хүснэгт №1

№	Байгууллага	2010 онд бүртгэгдсэн үзмэрийн тоо	УНБМСанд бүртгэгдсэн нийт үзмэрийн тоо
1	Монголын үндэсний музей	60	589
2	Байгалийн түүхийн музей	373	1300
3	Богд хааны ордон музей	1169	2370
4	Дүрслэх урлагийн музей	418	1619
5	Чойжин ламын сүм музей	69	102
6	Монголын театрын музей	1251	1823
7	Монгол цэргийн музей	70	189
8	Уран зургийн галерей	330	630
9	УБТШБМузей	16	407
10	Үндэсний номын сан	238	630
11	Гандантэгчинлэн хийд	-	0
12	ШУА-ийн Археологийн хүрээлэн	1	92
13	ШУА-ийн Палеонтологийн хүрээлэн	-	0
14	Архангай аймгийн музей	-	150
15	Баян-Өлгий аймгийн музей	182	478
16	Баянхонгор аймгийн музей	462	1062
17	Булган аймгийн музей	627	1156
18	Говь-Алтай аймгийн музей	232	487
19	Говьсүмбэр аймгийн музей	-	296
20	Дархан-Уул аймгийн музей	204	847
21	Дорноговь аймгийн музей	101	130
22	Дорнод аймгийн музей	480	1280
23	Дундговь аймгийн музей	306	568
24	Завхан аймгийн музей	459	1259
25	Орхон аймгийн музей	149	326
26	Өвөрхангай аймгийн музей	130	503

27	Хархорин. Эрдэнэ зуу музей	102	902
28	Өмнөговь аймгийн музей	20	842
29	Сүхбаатар аймгийн музей	189	350
30	Сэлэнгэ аймгийн музей	700	1500
31	Төв аймгийн музей	983	1403
32	Увс аймгийн музей	755	881
33	Ховд аймгийн музей	83	200
34	Хөвсгөл аймгийн музей	170	370
35	Хэнтий аймгийн музей	768	1200
36	Төрийн түүхийн музей	349	497
	<b>Нийт</b>	<b>11446</b>	<b>26438</b>

Хүлээн авсан бүртгэлийн байдлаас үзэхэд музейн бүртгэлийн бүрдүүлэлт дутмаг, үзмэрийн бүртгэн баримтжуулалтын гэрэл зураг авалтын чанар байдал харилцан адилгүй, чанарын шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байна. Музейнүүдээс УНБМСанд ирүүлсэн үзмэрийн бүртгэлийн бүрдүүлэлтийн байдлаас үзэхэд :

- Үзмэрийн талаарх үндсэн мэдээллийн хэсэг болох “Өмчлөгч”, “Эзэмшигч”, “Дурсгалын нэр”, “Хувийн дугаар”, “Дурсгалыг бүтээсэн материал”, “Хийсэн арга ажиллагаа”, “Дурсгалын хэмжээ” гэсэн асуулгуудыг 80 хувь бүрдүүлсэн,
- Үзмэрийн “Тодорхойлолт буюу дурсгалын өнгө, хэлбэр төрх, онцлог шинж, гэмтэл, өө сэв”, “Товч түүх”-ийн хэсэг буюу уг эд зүйлс хэрхэн бүтээгдсэн, хадгалж ирсэн байдал, музейд анх цуглуулсан, хамгаалалтад авсан, сэргээн засварласан, шилжилт хөдөлгөөн, судлагдсан байдал зэрэг тухайн эд зүйлсийн түүхтэй холбогдох мэдээлэл бүрэн бус бөглөгдсөн нь үзмэрийн бүртгэл бүрдүүлэлтийн 20 хувийг эзэлж байна.

Музейгээс ирүүлж байгаа бүртгэлийн бүрдүүлэлт нь:

- Музейн ажилтнуудын мэргэжил, мэдлэг, ур чадвараас хамаарч байна,
- Тухайн үзмэр музейд орсон авсан цагаас эхлэн түүний холбогдох намтар түүх, уг сурвалжийн талаар мэдээ, мэдээллийг музейд дутуу дулимаг бүрдүүлж ирсэн,
- Музейд үзмэрийг судлах эрдэм шинжилгээ, судалгааны ажил орхигдсон явдал нь музейн үзмэрийг бүртгэлийн бүрдүүлэлтийг бүрэн хангахад сөргөөр нөлөөлж байна.

#### 1.4 “Монголын музейн үзмэрүүд” гэрэл зургийн цомог, цахим каталоги хийх:

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 23-р тушаалаар “Монголын музейн үзмэрүүд” гэрэл зургийн цомгийн үзмэрийн гэрэл зураг авах, тодорхойлолт бэлтгэх ажлыг улсын болон 21 аймгийн музей, эрдэм шинжилгээний хүрээлэн, номын сан, сүм хийд зэрэг 40 байгууллагыг хамруулан 2010 оны 3-р сараас 7-р сарыг дуустал хугацаанд хийж гүйцэтгэлээ.

2009 оны 11 дүгээр сарын 05-нд Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас зарласан “Монголын музейн үзмэрүүд” гэрэл зургийн цомгийн үзмэрийн гэрэл зураг авах 1-р багцийн тендерийн сонгон шалгаруулалтад “Ирмүүнмальти медиа” ХХК шалгарсан.

БСШУЯамнаас тус компанитай 2010 оны 02 дугаар сарын 03-ны өдөр 2010/01 тоот “Монголын музейн үзмэрүүд” гэрэл зургийн цомгийн зураг авах ажил гүйцэтгэх

гэрээ”-г байгуулсны үндсэн дээр Соёлын өвийн төв, “Ирмүүнмальти медиа” ХХК-тай хамтран уг ажлыг гүйцэтгэв.

Соёлын өвийн төв, “Ирмүүнмальти медиа” ХХК-ийн хамтарсан 2 ажлын хэсэг зэрэг гарч Улаанбаатар хотод орших болон 21 аймгийн музейнүүд дээр биечлэн очиж, үзмэрийн гэрэл зураг авах, үзмэрийн талаарх тодорхойлолт бэлтгэх ажлыг зохион байгуулан ажиллалаа.

Гэрэл зургийн цомогт Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр хосгүй үнэт зэрэглэлд батлагдсан дурсгалууд болон музей тус бүрээс тодорхой тооны, шилдэгт тооцогдох үзмэрүүдийг хамруулах зорилтыг ханган ажилласан.

Дээр дурдсан 2010/01 тоот “Монголын музейн үзмэрүүд гэрэл зургийн цомгийн зураг авах ажил гүйцэтгэх гэрээ”-ний 1.5; 1.6 дахь шалгуур үзүүлэлтийг ханган, 1.4; 1.7-д заасны дагуу үзмэрийн гэрэл зургийг JPG өргөтгөлтэй, 4288 x 2848-аас 5616 x 3744 хүртэлх пиксель хэмжээтэйгээр 1 үзмэрт 4-12 хүртэлх ширхэг кадр зураг авсан.

Гэрэл зургийн цомог, цахим каталогит 5339 үзмэрийн гэрэл зургийг хамруулахаар төлөвлөснөөс 5339 үзмэрийн (36106 ширхэг кадр) гэрэл зургийг авсан.

Хүснэгт №2

**“Монголын музейн үзмэрүүд” гэрэл зургийн цомогт орох гэрэл зураг авч, тодорхойлолт бэлтгэсэн үзмэрүүдийн тоо**

№	Гэрэл зураг авагдсан газрууд	Анх төлөвлөсөн үзмэрийн тоо	Гэрэл зураг авагдсан, тодорхойлолт бэлтгэсэн үзмэрийн тоо	“Ирмүүнмальти медиа” ХХК-иас хүлээн авсан гэрэл зургийн кадрын тоо	Тайлбар
1	Монголын үндэсний музей	416	434	3843	
2	Төрийн түүхийн музей	100	259	562	
3	Байгалийн түүхийн музей	158	78	878	
4	Богд хааны ордон музей	312	334	2362	
5	Дүрслэх урлагийн музей	288	290	1679	
6	Чойжин ламын сүм музей	132	108	1123	
7	Монголын театрын музей	100	100	360	
8	Монгол цэргийн музей	150	148	666	
9	Уран зургийн галерей	200	199	656	
10	УБТШБ-ын музей	100	44	593	
11	Үндэсний номын сан	110	100	483	
12	Архангай аймгийн музей	150	148	698	
13	Баян-Өлгий аймгийн музей	150	156	1541	

14	Баянхонгор аймгийн музей	150	156	792	
15	Булган аймгийн музей	150	180	1310	
16	Говь-Алтай аймгийн музей	150	142	1347	
17	Говьсүмбэр аймгийн музей	50	28	199	
18	Дархан-Уул аймгийн музей	100	62	334	
19	Дорнод аймгийн музей	150	171	974	
20	Дорноговь аймгийн музей	120	125	505	
21	Данзанравжаагийн музей	7	12	272	
22	Дундговь аймгийн музей	150	148	578	
23	Завхан аймгийн музей	150	134	1698	
24	Орхон аймгийн музей	100	95	674	
25	Өвөрхангай аймгийн музей	150	152	913	
26	Эрдэнэ зуу музей	359	365	2165	
27	Өмнөговь аймгийн музей	150	143	575	СӨТ-д сэргээн засаж байсан 10 үзмэр нэмэгдсэн
28	Сүхбаатар аймгийн музей	150	149	906	
29	Сэлэнгэ аймгийн музей	100	92	549	
30	Төв аймгийн музей	150	150	963	
31	Увс аймгийн музей	150	141	1167	
32	Ховд аймгийн музей	150	148	1757	
33	Хөвсгөл аймгийн музей	150	135	983	
34	Хэнтий аймгийн музей	150	153	882	
35	Гандантэгчилэн хийд	13	15	565	
36	ШУА-ийн Палеонтологийн хүрээлэн	1	15	342	14 хосгүй үнэт дурсгал, зэрэглэлд хамрагдаагүй 1 дурсгал
37	ШУА-ийн Археологийн хүрээлэн	1	8	152	
38	Өвөрхангай аймаг, Шанхын Баруун хүрээ хийд	16	22	60	
39	Өвөрхангай аймаг,	1			Тус хийдэд буй 1



	Төвхөн хийд				ширхэг хосгүй үнэт дурсгалын зураг Соёлын өвийн төвд байгаа учраас аваагүй.
40	Эрдэнэсийн сан	5			Тус сан нь улсын нууц гэдэг шалтгаанаар 1999 онд хосгүй үнэтэд батлагдсан 5 дурсгал, 2010 онд батлагдсан 15 дурсгал /нийт 20/-ын гэрэл зургийг авахуулахыг зөвшөөрөөгүй тул зураг авагдаагүй.
	<b>Нийт дүн</b>	<b>5339 үзмэрийн зураг авахаас</b>	<b>5339 үзмэрийн гэрэл зургийг авсан.</b>	<b>36106 ширхэг гэрэл зургийн кадр</b>	

“Ирмүүнмальти медиа” ХХК-ийн авсан 5339 үзмэрийн гэрэл зургаас гадна Соёлын өвийн төвийн УНБМСанд хадгалагдаж буй 2003 онд Төвдийн сангийн тэтгэлгээр хийгдсэн “Монгол дахь Буддын шашны урлаг” каталогийн гэрэл зураг авагдсан 466 бүтээл, мөн Өвөрхангай аймгийн Төвхөн хийд, Эрдэнэсийн сангийн хосгүй үнэт 6 дурсгалын гэрэл зургийг нэмж оруулах юм.

Иймээс “Монголын музейн үзмэрүүд” гэрэл зургийн цомог, цахим каталогит нийтдээ 40 байгууллагын 5811 үзмэрийн гэрэл зураг, тодорхойлолт, мэдээлэл орохоор төлөвлөгдөж байна.

Хүснэгт №3

**“Монголын музейн үзмэрүүд” гэрэл зургийн цомогт орох нийт үзмэрийн тоо**

№	Үзмэрийн гэрэл зургийн бүрдэл	“Монголын музейн үзмэрүүд” гэрэл зургийн цомогт орох үзмэрийн тоо
1	“Ирмүүнмальти медиа” ХХК-ний авсан үзмэрийн гэрэл зургийн тоо	5339
2	Соёлын өвийн УНБМСанд хадгалагдаж буй “Монгол дахь Буддын шашны урлаг” каталогит орсон үзмэрүүдийн гэрэл зураг	466
3	Соёлын өвийн УНБМСанд хадгалагдаж буй Төвхөн хийд болон Эрдэнэсийн сангийн хосгүй үнэт дурсгалын зураг	6

	<b>Гэрэл зургийн цомогт орох нийт үзмэр</b>	<b>5811</b>
--	---	-------------

“Ирмүүнмальти медиа” ХХК-иас хүлээн авсан үзмэрийн гэрэл зургийн хувийг DVD-д бичиж, улсын болон 21 аймгийн музей, эрдэм шинжилгээний хүрээлэн, Үндэсний номын сан, Гандантэгчинлэн хийд тус бүрийн бүртгэл-мэдээллийн санд хүлээлгэж өгсөн болно. (Ажлын тайлан Соёлын өвийн төвд хадгалагдаж байгаа)

Үзмэрийн тодорхойлолт бэлтгэлийн талаар:

БСШУ-ны сайдын 2009 оны 303-р тоот тушаалаар Ажлын хэсэг байгуулан, гэрэл зургийн цомог, цахим каталоги хийх ажлыг зохион байгуулахыг үүрэг болгосон.

Ажлын хэсэг нь гэрэл зургийн цомог, цахим каталогийг хийх арга хэлбэрийг тогтож, ажлын төлөвлөгөө, гишүүдийн ажил үүргийн хуваарь, ажлын чиглэлийг боловсруулж, БСШУЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын батласны дагуу цомгийн гол ажил болох үзмэрийн тодорхойлолт бэлтгэх ажлыг гэрэл зураг авахтай зэрэгцэн ажлыг хийж гүйцэтгэлээ.

Гэрэл зургийн цомог нь үндсэн 2 бүлэгтэй байх бөгөөд тэргүүн бүлэгт Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор түүх, соёлын хосгүй үнэт зэрэглэлд батлагдсан дурсгалууд байна.

Дэд бүлэг буюу 2-р бүлэгт 33 музей тус бүрийн эхний хуудсанд тухайн музейн танилцуулга байхаар төлөвлөн танилцуулгыг музей тус бүрээр нь бэлтгэв.

Цомогт орох үзмэрийн тодорхойлолтыг “Дурсгалын нэр, “Бүтээлч”, “Холбогдох он цаг”, “Музейн нэр”, “Дурсгалын шинж байдал”, “Хувийн дугаар”, “Тодорхойлсон үндэслэл” гэсэн агуулга бүхий үзмэр тус бүрээр бэлтгэсэн болно.

Үзмэрийн гэрэл зураг авагдахаас өмнө тодорхойлолтыг бэлтгэх заавар зөвлөмжийг боловсруулан бүх музейнүүдэд тараан, үзмэрийн тодорхойлолт бэлтгэх ажлыг гүйцэтгэв. Цомогт орох үзмэрийн тодорхойлолтыг “Музейн үзмэр, эд өлгийн зүйлсийн ерөнхий бүртгэл”-ийн дэвтрийг баримтлан бичсэн ба зарим үзмэрийн түүхийн үнэ цэнийг тодорхойлоход чухал өгөгдөл болох “нэр”, “хэмжээ”, “материал”, “бүтээсэн он цаг” зэргийг алдаатай, буруу ташаа бүртгэсэн явдал гарч байна.

Соёлын өвийн төвийн мэргэжилтэнүүд үзмэрийн тодорхойлолтыг зааврын дагуу бэлтгэхэд байнга арга зүйн зөвлөмжийг байнга өгч ажилласан ба музей тус бүрийн үзмэрийн тодорхойлолт бичлэгийг нягтлан шалгаж Ажлын хэсгийнхэнд хүлээлгэж өгөөд байна.

Музейд, ялагуяа орон нутгийн музейд эрдэм шинжилгээний ажилтны орон тоо байх боловч төсвийн цалин мөнгө дутуу ирдгээс орон тоогоороо бүрэн ажилладаггүй, судалгаа шинжилгээний ажил орхигдсон, сүүлийн жилүүдэд худалдан авсан үзмэрүүдэд хуурамч, дууриамал байж болзошгүй үзмэрүүд нэлээдгүй байгааг анхаарч үзүүштэй. (Ажлын дэлгэрэнгүй тайлан Соёлын өвийн төвд хадгалагдаж байгаа)

Цахим каталоги хийх талаар:

Цахим каталоги боловсруулах ажлын тендерт заасны дагуу “Сайбер-Андромеда” ХХК-наас 2010 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр дараах 6 нэр төрлийн тоног төхөөрөмжийг хүлээн авав. Эдгээр тоног төхөөрөмжүүд нь уг ажлыг хийхэд цуглагдсан мэдээллийг хадгалах, гэрэл зургийн 1 хувийг өндөр нягтаршилтайгаар эзэмшигч музейнүүдэд DVD/CD-ээр хүлээлгэн өгөх, цахим каталогийн мэдээллийг боловсруулах, хэвийн ажиллагааг хангах зэрэгт ашиглагдах юм.

д/д	Тоног төхөөрөмжийн нэр	Дэлгэрэнгүй үзүүлэлт	Тоо ширхэг
1	Сервер компьютер	Брэнд: DELL Марк: POWER EDGE R710 Процессор: Xeon Шуурхай санах ой: 8 Гигабайт (Gb) Хатуу диск: 5 терабайт (Tb) Raid controller: Raid 5 controller Тэжээл: Цуваагаар ажиллах 2 тэжээлийн блок Серверийн төрөл: Хэвтээ Rack mount Оптик төхөөрөмж: DVD-RW	1ш
2	Зөөврийн компьютер	Процессор: Core 2.14Ghz i3 Шуурхай санах ой: 4 Гигабайт (Gb) Хатуу диск: 500 Гигабайт (Gb) График карт: 1024 Мегабайт (Mb) Оптик төхөөрөмж: DVD-RW, Blu-ray Дэлгэц: 15.1 инч (inch)	1ш
3	Зөөврийн Хард диск	Багтаамж: 500Gb Оролт: USB 2.0	3 ш
4	Wireless access point	Mercury MW548R with 7 Lan ports	1ш
5	CD	Хатуу хайрцагтай, Багтаамж: 700Mb, 80 мин	500 ш
6	DVD	Хатуу хайрцагтай, Багтаамж: 4.7 Gb	500 ш

Соёлын өвийн төвөөс соёлын биет өв болох хөдлөх, үл хөдлөх дурсгал, соёлын биет бус өвийг олон нийтэд таниулан сурталчлах зорилгоор [www.eheritage.mn](http://www.eheritage.mn) домайн нэрийн дор [www.movable.eheritage.mn](http://www.movable.eheritage.mn), [www.immovable.eheritage.mn](http://www.immovable.eheritage.mn), [www.intangible.eheritage.mn](http://www.intangible.eheritage.mn) гэсэн төрөлжсөн цахим хуудсыг ашиглалтанд оруулахаар ажиллаж байна. Цахим каталоги нь соёлын өвийг хадгалж хамгаалах, сурталчлах зорилготой, монголын соёлын өвийн мэдээллийн сайт юм.

Дээрхи гэрэл зургийн цомгийн хэрэглэгдэхүүнд тулгуурлан хийгдэх цахим каталоги нь [www.movable.eheritage.mn](http://www.movable.eheritage.mn) домэйн хаягтай байна. БСШУЯамнаас зарласан цахим каталоги хийх ажлын гүйцэтгэгч байгууллагаар “Сайбер-Андромеда” ХХК шалгаран, уг ажлыг гүйцэтгэж байна.

[www.movable.eheritage.mn](http://www.movable.eheritage.mn) цахим каталогт улс, аймгийн музейн шилдэг үзмэрийн мэдээллийг монгол, англи хэл дээр гаргаж, тухайн үзмэрийн гэрэл зураг байрлана. Мөн уг үзмэрийн эзэмшигч байгууллагуудын товч танилцуулга, веб сайтын хаягууд байна.

Цахим каталогийн мэдээлэл нь соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сан (RCH 2.0)-ын мэдээллийн баазаас шууд холбогдож болох бөгөөд цаашид хамрагдах үзмэрийн тоо нэмэгдэх бүрэн боломжтой байхаар зохион байгуулагдсан.

Энэхүү цахим каталоги нь хулгайд алдсан болон хил гааль дээр хураагдсан түүх, соёлын дурсгалын тухай мэдээллийн дэд системтэй бөгөөд уг системийг ашиглан эрх бүхий байгууллагууд (музей, хил гааль, цагдаа г.м) цаг алдалгүй түргэн шуурхай мэдээллээ солилцох боломжтой болох юм.

“Монголын музейн үзмэрүүд” гэрэл зургийн цомгийн англи хэлний орчуулга, хэвлэлийн эх бэлтгэлийн талаар:

Гэрэл зургийн цомгийн 2 дахь шатны ажил нь англи хэлний орчуулга, хэвлэлийн эх бэлтгэлийн ажил юм.

“Монголын музейн үзмэрүүд” гэрэл зургийн цомгийн хэрэглэгдэхүүнийг англи хэл рүү орчуулах үйлчилгээний тендерийг БСШУЯ-наас 2010 оны 11 сарын 15-ны өдөр хэвлэлийн мэдээллийн хэрэгслээр зарлаж, тендерийн нээлтийг 2010 оны 11-р сарын 30-ны өдрийн 11 цаг 30 минутад нээсэн. Уг тендерийн шалгаруулалтад 1 хүн саналаа ирүүлсэн боловч шаардлага хангаагүй. Иймд англи хэл рүү орчуулах үйлчилгээний сонгон шалгаруулалтыг дахин явуулахаар БСШУЯаманд хандаад байна.

Цомгийн англи хэлний орчуулга бүрэн хийгдэж дууссан дараа хэвлэлийн эх бэлтгэл хийгдэх тул орчуулгын ажлаас шалтгаалан хэвлэлийн эх бэлтгэх, цомгийг хэвлэх ажил мөн хойшлогдон 2011 оны эхээр хийхээр төлөвлөөд байна.

2010 оны 11 дүгээр сард “Монголын музейн үзмэрүүд” гэрэл зургийн цомгийн эх бэлтгэх, хэвлэхтэй холбоотой асуудлаар тендерийн хороо хуралдсан ба уг хурлаар цомгийг хэвлэх газар нь хэвлэлийн эхийг хамтад нь бэлтгэх нь зүйтэй гэж үзсэн.

### **1.5 Төрийн түүхийн музей, Эрдэнэсийн сан, Археологийн хүрээлэнд хадгалагдаж байгаа зарим дурсгалыг түүх, соёлын хосгүй үнэт зэрэглэлд батлуулах**

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу түүх, соёлын дурсгалт зүйл хадгалагдаж буй Төрийн түүхийн музей, Эрдэнэсийн сан, ШУА-ийн Палеонтологийн хүрээлэн, Археологийн хүрээлэн зэрэг газруудаас ирүүлсэн саналыг үндэслэн дурсгалуудыг түүх, соёлын хосгүй үнэт зэрэглэлд батлуулах ажлыг зохион байгуулан ажилласан.

Түүх, соёлын дурсгалт зүйлийг жагсаалтанд Монгол төрийн түүхийн музейн сан хөмрөгт хадгалагдаж байгаа XIII-XIV зууны үеийн алт, мөнгө, зэс зоос, булшнаас олдсон XIII-XIV зууны язгууртны хувцас хэрэглэл, Х.Чойбалсангийн хэрэглэж байсан эд зүйлс нийт 259 дурсгал, Монгол банкны Эрдэнэсийн санд хадгалагдаж байгаа VIII Богд Жавзундамба хутагтын алт, мөнгө, хаш тамга, тамганы хайрцаг, алтан чимэглэлтэй хэт хутга, эрхи, алтан өргөмжлөл, Эх дагины мөнгөн тамга зэрэг нийт 15 дурсгалыг, ШУА-ийн Палеонтологийн төвд хадгалагдаж байгаа тарбозавр, галлимимус, протоцератопс, адазавр, овираптор, сегнозавр, эрликозавр, ахиллобатор зэрэг динозаврын чулуужсан араг яс, бөөнөөр хадгалагдсан зулзага, өндөгний үүр зэрэг нийт 25 олдворыг, ШУА-ийн Археологийн хүрээлэнд хадгалагдаж байгаа мөнгөн хөөмөл чимэггэл, ясан хэл хуур, малгай, дээл, гутал хувцас зэрэг 5 түүхийн үнэ цэнэтэй олдвор, эх сурвалж хэрэглэгдэхүүн нийт 304 дурсгал Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 103 дугаар тогтоолоор нэмж батлагджээ.

№	Байгууллагын нэр	Хосгүй үнэт зэрэглэлд батлагдсан дурсгалын тоо
1	Төрийн түүхийн музей	259
2	Эрдэнэсийн сан	15
3	ШУА-ийн Археологийн хүрээлэн	5
4	ШУА-ийн Палеонтологийн хүрээлэн	25
	2010 онд хосгүй үнэт зэрэглэлд батлагдсан дурсгал	304

Эдгээр батлагдсан хосгүй үнэт дурсгалууд нь хүннү болон пазырыкийн үеийн археологийн олдворууд, зөвхөн монголоос олдсон шинжлэх ухаанд томоохон нээлт болсон палеонтологийн ховор олдворууд, Чингисийн үеийн алтан зоос, Богд хаант Монгол Улсын үеийн түүхэнд холбогдох түүх, соёлын ховор нандин дурсгалууд юм.

2010 онд 304 үзмэр, эд өлгийн зүйл түүх, соёлын хосгүй үнэт зүйлийн жагсаалтад нэмж батлагдснаар Монгол Улсын Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл 593 болсон байна.

### **1.6 2008-2009 онд бүртгэгдсэн үл хөдлөх дурсгалыг RICH програм хангамжинд шилжүүлэх**

Монгол Улсын Сангийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайдын 2006 оны 09-р сарын 27-ны өдрийн 299/324/111 тоот хамтарсан тушаалаар “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл болох булш, хиргисүүр, хадны зураг, бичээс, хөшөө чулуу, сүм хийд, түүний үлдэгдэл, эртний хотын туурь, түүхт овоо, суврага зэргийг бүртгэх тоолох” ажлаар 2008, 2009 онуудад хамрагдсан Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Дорноговь, Говьсүмбэр аймгуудын түүх соёлын үл хөдлөх дурсгалуудын бүртгэлийг тоон системд шилжүүлэх ажлыг хийж эхлүүлээд байна.

Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр”-ийн хүрээнд үл хөдлөх дурсгалыг бүртгэх “RICH буюу registration of immovable cultural heritage” програмыг боловсруулан, 2009 оноос туршилтаар ашиглаж эхэлсэн. 2010 оны сүүлийн байдлаар Дорнод, Дорноговь, Говьсүмбэр зэрэг аймгийн 394 газрын 3012 дурсгалын бүртгэлийг “RICH” програм хангамжид шилжүүлсэн.

Энэхүү программ хангамжийн мэдээллийн баазыг дахин өргөтгөх, хайлтын үйлдлийг боловсронгуй болгох, дурсгалт газрыг газрын зурагт байрлуулах холбоосыг хялбарчилах, шинээр батлагдсан үл хөдлөх дурсгалын бүртгэлийн маягтын өөрчлөлтүүдийг нэмэх зэрэг хэд хэдэн засварыг хийх шаардлагатай болсон тул програмд дурсгал бүртгэх ажлыг түр хугацаагаар зогсоогоод байна. Дээр дурдсан засварын ажлуудыг 2011 оны нэгдүгээр улиралд багтаан дуусгаж програмд үл хөдлөх дурсгалыг бүртгэх бүртгэлийн ажлыг хэвийн үргэлжлүүлэх болно.

### **1.7 2010 оны “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах сэргээн засварлах хөтөлбөр”-ийн 7.2-3, 7.2-4 Шивээт улаан дурсгалын зөөгдсөн зарим хөшөөг унаган газар нь байрлуулах**

Монгол улсын Засгийн газрын 2007 оны 303 дугаар тогтоолоор батлагдсан “Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр”-ийн 7.2.3-т заасан Булган аймгийн Баян-Агт сумын нутагт орших Шивээт улааны цогцолбор дурсгалаас тодорхой бус цаг хугацаанд зөөвөрлөгдсөн дурсгалуудыг буцааж унаган газарт нь аваачиж байрлуулах ажлыг Соёлын өвийн төвийн захирал Г.Энхбат, сэргээн засварлагч С.Чинзориг, Г.Соёл-Эрдэнэ, Ж.Даваадарь нар 2010 оны зургаадугаар сарын долооноос 11-нд хооронд хийж гүйцэтгэв.

Шивээт улааны цогцолбор дурсгалуудаас Орхон аймгийн музейн үүдэнд хоёр (Хүн чулуун хөшөө, Арслангийн (чоно) дүрс бүхий чулуун баримал), Архангай аймгийн Хайрхан сумын төвд дөрвөн (Тамга тэмдэг сийлсэн гэрэлт хөшөө, Арслангийн дүрстэй болон хэвтэж буй хонины дүрс баримал) дурсгал, нийт зургаан чулуун дурсгал зөөгджээ.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 17.1, 17.9 дүгээр заалтын дагуу түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг авран хамгаалах, унаган газар нь эргүүлж байршуулах тухай албан бичгийг БСШУ-ны сайдаас тухайн орон нутгийн шат, шатны Засаг дарга нарт албан бичгээр мэдэгдэн зохих зөвшөөрөл, хэлцлийг хийж, уг ажлыг гүйцэтгэлээ.

Орхон аймгийн Засаг дарга Д.Оюунбатын 2010 оны тавдугаар сарын 26-ны 1/877 тоот албан бичгийн дагуу Орхон аймгийн музейн үүдэнд байсан хоёр ширхэг чулуун дурсгалыг татаж авах ажлыг хийв. Музейн үүдэнд байсан арслангийн дүрст хөшөөг цементэн сууринд хийж суулгасан байсныг хөшөөнд нь аюул, хохирол гэмтэл учруулалгүй цэвэрлэгээ хийж авав.

Ажиллах үед тус аймгийн Засаг даргын тамгын газрын мэргэжилтэн Ж.Сандуйжав, Боловсрол, соёлын газрын дарга Ц.Ариунаа болон аймгийн музейн захирал А.Дүүрэн нар байлцав.

Архангай аймгийн Хайрхан сумын төвд хонины нэг, толгойгүй арслангийн нэг, сумын хийдийн дэргэд гэрэлт хөшөө нэг, айлын малын хашааны дэргэд хуцны нэг дурсгал тус тус байв.

Тус сумын хийдийн үүдэнд мөргөлийн суурь чулуу болгон ашиглаж байсан тамга тэмдэг бүхий дүрс сийлбэрлэсэн гэрэлт хөшөө, сумын төвөөс хойш 10-аад км-т орших малчин Гуа-Амгалангийн өвөлжөөний хонины хашааны үүдэнд байсан хонины дүрс бүхий баримлын дурсгалыг Шивээт улаан руу буцаан байрлуулав.

Энэхүү ажлын үеэр Хайрхан сумын удирдлагууд уг дурсгалуудыг унаган газарт нь буцаан байрлуулах тухай БСШУ-ны сайдын болон аймгийн Засаг даргын тушаалыг үл тоомсорлон хонь болон арслангийн дүрстэй хөшөөнүүдийг сумын Соёлын төвийн барилгад нууж цоожилсоны учир дээрх хоёр дурсгалыг зөөлгүй үлдээсэн болно.

Сумын удирдлагууд дээрх хоёр хөшөөг Шивээт улааны дурсгалаас ирээгүй, өөр газраас авчирсан учир өгөхгүй гэх зэрэг бүдэг бадаг тайлбар өгч байлаа. Эцэст нь ажлын хэсгээс ШУА-ийн Археологийн хүрээлэнгээс тус суманд буй эдгээр дурсгалууд нь Шивээт улаанаас зөөгдсөнийг баталгаажуулсан дүгнэлт ирүүлэх, уг дүгнэлт ирсний дараа сумын удирдлага өөрсдөө тэдгээрийг унаган газар нь буцаан байрлуулахаар тогтов.

Архангай аймагт ажиллах үед Хайрхан сумын Засаг даргын орлогч Ч.Чулуунбаяр, ИТХ-ын дарга Д.Батсүх, сумын соёлын төвийн эрхлэгч Г.Дэлгэрмядаг, соёлын төвийн ажилтан Ж.Баярсайхан нар хамт байлцав.

Булган аймгийн Баян-Агт сумын нутаг дахь Шивээт улаан хэмээх газарт орших түргийн үед холбогдох цогцолбор дурсгалуудаас зөөгдсөн зургаан дурсгалын дөрвийг нь ийнхүү унаган газарт буцаан байрлууллаа.

Дурсгалуудыг буцаан байрлуулах ажлын үеэр Баян-Агт сумын залуус Шивээт улааны цогцолбор дурсгалаас зүүн хойш нэгэн толгойн орой дээр байдаг нутгийнхны “Баатарын толгой” гэж нэрлэдэг хүн чулууны толгойг авчирч үзүүлэв. Энэхүү толгой нь Шивээт улааны хүн чулуун дурсгалыг үйлдсэн чулуулагтай адил байсан бөгөөд уг цогцолбор дурсгалын нэгэн хүн чулууны толгойн хэсэг байх магадлалтай юм. Иймд уг хүн чулууны толгойн хэсгийг Баян-Агт сумын Засаг даргын тамгын газар, сумын Соёлын төвд хадгалуулахаар болов. Цаашдаа тус цогцолборын эвдрэл гэмтлийг нь наах, бэхжүүлэлтийн ажлыг хийх шаардлагатай байна. (Ажлын дэлгэрэнгүй тайлан Соёлын өвийн төвд хадгалагдаж байгаа)

Нэмэлт хийгдсэн ажил: Үл хөдлөх дурсгалыг гурван хэмжээс (3D measurement) –т дижитал технологиор бүртгэсэн талаар:

2010 оны нэгдүгээр сард БСШУЯ-ны харьяа Соёлын өвийн төв, Япон улсын Дошишагийн Их Сургуулийн Соёлын өвийн мэдлэг судалгааны төвийн хооронд монгол улсын нутаг дахь чулуун хөшөө дурсгал болон музейн зарим үзмэрийг гурван хэмжээст дижитал технологиор бүртгэн баримтжуулах чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцон харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан билээ.

Энэ санамж бичгийн дагуу хоёр байгууллагын мэргэжилтэн судлаачид 2010 онд Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын нутаг Дунд Жаргалантын адаг хэмээх газар орших буган чулуун хөшөө болон мөн аймгийн Батширээт сумын нутаг Баянголын амны хүн чулуун хөшөөг гурван хэмжээст дижитал технологиор баримтжуулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Уг судалгааны ажилд монголын талаас Соёлын өвийн төвийн үл хөдлөх дурсгал хариуцсан мэргэжилтэн Б.Даваацэрэн, програмист Б.Алтансүх, Японы талаас Дошиша их сургуулийн судлаач, мэргэжилтэн Ямагучи, Нацуки нар оролцсон болно.

Судалгааны ажлын хүрээнд Дунд Жаргалантын нэгдүгээр буган хөшөө болон Баянголын амны хүн чулууг гурван хэмжээст лазер хэмжилтийн багажаар хэмжиж баримтжуулах ажлыг хийсэн юм. Судалгааны ажлын эцсийн үр дүнг нэгтгэн боловсруулж хараахан дуусаагүй байгаа бөгөөд боловсруулалтын ажлын эхний үр дүнгээс харахад цаашид ийм аргаар хөшөө дурсгалыг баримтжуулах болон боловсруулсан гурван хэмжээст моделийг сургалт, сурталчилгаанд ашиглах бүрэн боломжтой болох нь харагдаж байв. Бид цаашид энэ төслийн хүрээнд Дорнод Монголын нутагт буй хүн чулуун дурсгалуудыг баримтжуулах ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөөд байна.

## **БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АНГИ-2. СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ**

### **2.1 Соёлын биет бус өв (СББӨ)-ийг бүртгэн баримтжуулах програм хангамжийн техникийн өгөгдөл бэлдэх тухай.**

Монгол Улсын хэмжээнд байгаа бүх СББӨ, түүнийг өвлөн уламжлагчийн талаарх эрдэм шинжилгээний үнэн зөв бодит мэдээллийг цуглуулан авахад зориулж, тусгайлан боловсруулсан өгөгдөл бүхий бүртгэн баримтжуулах програм хангамж зохиох, бүртгэл хийх байгууллагыг зөвхөн энэ ажилд зориулан өндөр хүчин чадалтай компьютер, гэрэл зургийн техник тоног төхөөрөмжөөр хангах, интернет шугам сүлжээ үүсгэх, СББӨ-ийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сүлжээ, электрон архив сан үүсгэн бий болгох, мэдээлэл нэгтгэх, боловсруулах ажлыг зохион байгуулах, үндэсний СББӨ-ийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах нь зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай зорилтуудын нэг болж байна.

Үүнээс улбаалан “**Intangible cultural heritage of Mongolia (ICHMON)**” нэр бүхий Монгол Улсын Соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийг бүртгэх бүртгэлийн програм нь БСШУ-ны сайдын 2010 онд 541-р тушаалаар шинэчлэн баталсан “Соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийг бүртгэн баримтжуулах бүртгэл”-ийн ерөнхий хэв загварыг баримтлан ажиллахаар хийгдэж байгаа болно.

Энэхүү програм нь аймаг, нийслэл, сум, дүүргийн нэгж байгууллагад буй СББӨ, түүнийг өвлөн уламжлагчийн талаарх дэлгэрэнгүй, үнэн зөв бодит мэдээллийг тусгайлан бэлдсэн асуулт, өгөгдлийн дагуу бичиж архивлан хадгалах, цуглагдсан мэдээллийг нэгтгэн боловсруулах, хүссэн мэдээллээ түргэн хугацаанд олж авахад зориулагдсан. Програм нь гэрэл зургийн өгөгдөл оруулах, интернет шугаманд ажиллах боломжоор хангагдсан байх болно.

**“Intangible cultural heritage of Mongolia (ICHMON)”** програм нь хангамж нь СББӨ, түүнийг өвлөн уламжлагчийг бүртгэх 2 төрлийн бүртгэлийг уялдуулсан програм хангамж байна. Үүнд:

### **I. СББӨ, түүнийг өвлөн уламжлагчийн бүртгэл**

Уг бүртгэлээс Өвлөн уламжлагчийн мэдээлэл (нэр, нас, хүйс, регистрийн дугаар, байршил, алдар цол, гавьяа шагнал, хаяг, холбоо барих мэдээлэл г.м), СББӨ-ийг өвлөн уламжлагчийн тоог насны ангиллаар, бүс нутгаар, аймаг, сум, дүүргээр болон мөн ангилал, төрөл зүйл тус бүрээр нарийвчлан гаргах зорилгыг чиглэл болгон зохионо.

Мөн өвлөн уламжлагчийн тухайн өвөө үйлдэж буй дуу, дүрс бичлэг, гэрэл зургаас хэсэгчлэн оруулахдаа тэдгээрийн архивт хадгалагдаж буй дугаарласан дугаарыг програмд хавсаргаж өгнө.

### **II. СББӨ-ийн тухай мэдээлэл**

СББӨ-ийг өвлөн уламжлагчийн бүртгэл, тухайн хүний өвлөсөн биет бус өвийн тухай мэдээлэл дээрээс үндэслэн зөвхөн СББӨ-ийн илэрхийллийн тухай ерөнхий, нэгдсэн мэдээлэл гаргана. Үүнд:

1. СББӨ-ийн илэрхийллийг тайлбарласан тодорхойлолт, зурагтай хамт байна.
2. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгаа нийт СББӨ-ийн илэрхийллийн тоо, тэдгээрийн ангилал, төрөл зүйл бүрийн тоог гаргана.
3. СББӨ-ийн төрөл зүйл тус бүрийн Монгол Улсын хэмжээн дэх тархац газрын зураг дээр харагдах байдлаар гарна.

2010 оны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний 2.1 буюу “Соёлын биет бус өвийг бүртгэн баримтжуулах програм хангамжийн техникийн өгөгдөл бэлдэх тухай” ажлын хүрээнд эхний ээлжинд “СББӨ, түүнийг өвлөн уламжлагчдыг бүртгэх” програмын ажиллах зарчим, ерөнхий загвар, дизайныг хайлтын систем бүхий хялбарчилсан байдлаар ашиглах зориулалтаар боловсруулан гаргасан болно.

Уг бүртгэлийн програмыг ашиглан СББӨ, түүнийг өвлөн уламжлагчдын талаар төрөл бүрийн нарийвчилсан статистик мэдээлэл гарган авч цаашид УБМС-н боловсруулан сайжруулах, СББӨ-ийг хадгалж хамгаалах, хойчид өвлүүлэх, түүнийг өвлөн уламжлагчдыг дэмжих талаар судалгаа гаргах, хөтөлбөр боловсруулахад дөхөм болоход нэн шаардлагатай юм. Бүртгэлийн програмыг СББӨ, түүнийг өвлөн уламжлагчийг бүртгэн баримтжуулах ажил хийх эрдэм шинжилгээний ажилтнууд өргөн хэрэглэхээр техникийн өгөгдлийг боловсруулсан.

### **2.2 Соёлын биет бус өвийг хамгаалах Үндэсний хөтөлбөр боловсруулах тухай.**

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, Төрөөс баримтлах соёлын бодлого, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хуульд ардын уламжлалт урлагийг төрийн ивээлд байлгаж, тэдгээрийг судлах, сургаж эзэмшүүлэх, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, утга соёлын өв тээгчдийг тодруулан алдаршуулах, тэдэнд дэмжлэг үзүүлэх талаар заасан байдаг.

Орчин цагийн Монголын нийгэмд гарч буй хамгийн том өөрчлөлт бол сууриншил үйл явц эрчимжиж, нүүдлийн иргэншил эргэлт буцалтгүй задарч байгаа явдал юм. Эдүгээ Монголын хүн амын 3/2 хувь нь төв суурин газар, талаас илүү хувь нь нийслэл хотдоо оршин сууж буй статистик гарчээ. Монголын хотжилт нь ард иргэдийн жирийн нэг шилжих хөдөлгөөн биш, амьдралын нэг хэв маягаас огт өөр хэв маягт шилжих



шилжилт юм. (нүүдэллэн аж төрөх ёсноос суурин аж төрөх ёсонд). Хотжисноор хүмүүсийн зөвхөн амьдралын орон зай өөрчлөгдөөд зогсохгүй, ахуй амьдрал, хэв заншил, уламжлалт соёлын олон үнэт зүйлс үндсээрээ өөрчлөгдөхөд хүрч байгаа билээ. Ийм тохиолдолд нүүдлийн амьдралаас гарч, түүний салшгүй хэсэг болсон биет бус соёлын олон төрөл зүйлс түүний дотор мал аж ахуйн уламжлалт технологи, мал аж ахуйтай холбоотой, хур мэдлэг, туршлага ашиглагдахаа болж, нүүдлийн ёс заншил, гоо сайхны үнэлэмж, уртын дуу, үлгэр туульс, ардын бүжиг, бии биелэг, наадам, тоглоом нь хотын амьдрал, машин техникийн хэмнэлтэй төдийлөн таарахгүй учир орчин үеийн шоу цэнгээн, арилжааны соёлын хэрэглээгээр арга буюу солигдоход хүрч байна. Ийм эгзэгтэй хариуцлагатай үед Монгол улсын СББӨ, түүнийг өвлөн уламжлагчыг судлан тогтоож эрдэм авьяасыг нь хойч үед өвлүүлэх, хадгалж хамгаалах, СББӨ-ийн талаар урт хугааны цогц хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага гарч байна.

Соёлын биет бус өвийг хадгалж, хамгаалах, судлах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх хөтөлбөрийг боловсруулах бэлтгэл ажлын судалгаа шинжилгээний ажлын хүрээнд аймаг, нийслэлийн СББӨ, түүнийг өвлөн уламжлагчын судалгаа, Яаралтай хамгаалах өв, Монгол улсын төлөөллийн бүртгэлд олуулах өвийн санал, соёлын биет бус өвийн анхан шатны бүртгэл, тооллогыг 2010 оны нэгдүгээр улиралд хийж, дүнгээ аймаг, нийслэлийн салбар зөвлөлд ирүүлсэн бөгөөд аймаг, нийслэлээс нэгтгэн ирүүлсэн бүртгэл, жагсаалтыг нэгтгэн боловсруулж, 2010 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгон дүгнэв. Энэхүү судалгаа нь СББӨ-ийг хадгалж хамгаалах үндэсний хөтөлбөрийг боловсруулахад ихээхэн ач холбогдолтой бөгөөд судалгаагаар илрүүлсэн аймаг, нийслэлийн Яаралтай хамгаалах өв, Монгол улсын төлөөллийн бүртгэлд оруулах өвийн санал зэргийг харгалзан хөтөлбөрийг боловсруулж байна.

**Зорилго:** Соёлын биет бус өвийг бүртгэн баримтжуулах, бүртгэл-мэдээллийн сан түүний тогтолцоог бүрдүүлэх, авран хамгаалах, судлан сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилготой.

#### **Зорилт:**

1. Монгол улсын хэмжээнд соёлын биет бус өвийн УНБМС-ийн тогтолцоо бүрдүүлэх
2. Монгол улсын хэмжээнд соёлын биет бус өвийн бүхий л төрөл зүйлээр хэрэглэгдхүүн цуглуулах, бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх
3. Соёлын биет бус өвийг авран хамгаалах, судалгаа шинжилгээ хийх /судалгааны эргэлтэнд оруулах/
4. Монгол улсын Үндэсний төлөөллийн болон Яаралтай хамгаалах шаардлагатай өвийн бүртгэлийг нэмэгдүүлэх
5. ЮНЕКО-ийн Хүн төрөлхтний төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн жагсаалтад нэр дэвшүүлэх
6. Дэлхийн өвд бүртгэгдсэн “Увс нуурын ай сав газар” байгаль соёлын өв, “Орхоны хөндийн түүх соёлын дурсгалт газар” болон урьдчилсан жагсаалтад орсон газар нутагт СББӨ-ийн чиглэлээр бүс нутгийн хэмжээнд бүртгэн баримтжуулалт хийх
7. СББӨ-ийг түгээн дэлгэрүүлэх тэнхмийн болон шавь сургалт явуулах
8. СББӨ-ийг сурталчлах, хэвлэмэл болон дижитал, электрон танилцуулга, цомог, ном, CD, DVD, баримтат кино хийх
9. СББӨ-ийн талаар сургалт семинар, уулзалт ярилцлага, симпозиум, уралдаан наадмыг зохион байгуулах

10. Соёлын өвийн төв, СББӨ-ийг хамгаалах чиглэлээр ажилладаг судалгаа шинжилгээний хүрээлэн, музей холбогдох байгууллагыг тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах
11. СББӨ-ийн чиглэлээр боловсон хүчин, мэргэжилтэн бэлдэх
12. СББӨ-ийг сурталчлах цахим хэлбэрийн болон бодит хэрэглэгдхүүн дээр тулгуурласан “Соёлын биет бус өв”-ийн төрөлжсөн музей байгуулах
13. Өвлөн уламжлагчыг таньж тогтоох, жагсаалт гаргах, улсаас санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлэх зэрэг зорилготой байна.

Соёлын өвийн төвөөс Соёлын биет бус өвийг хамгаалах ажилд зориулсан үйл ажиллагааны зардал байхгүй байна. Иймд соёлын биет бус өвийг хамгаалах ажилд зориулсан тодорхой үйл ажиллагаа явуулах, энэхүү ажилд төрийн болон төрийн бус, олон нийтийн байгууллага, судлаачид, иргэлийг хамруулан оруулж тодорхой үүрэг хүлээлгэн ажиллуулах шаардлагатай байгаа тул БСШУЯамнаас энэхүү хөтөлбөрийг дэмжихийг хүсэж байна.

### **2.3 Соёлын биет бус өвийг уламжлан тээгчдийн улсын нэгдсэн бүртгэл, жагсаалтыг эхний хувилбараар гаргаж БСШУЯамны “Соёлын биет бус өв, түүний тээгчдийг тогтоох үндэсний зөвлөл”-өөр хэлэлцүүлнэ.**

Монгол Улсын төрөөс баримтлах соёлын бодлого, Соёлын өвийг хамгаалах тухай Монгол улсын хууль, Соёлын биет бус өвийг хамгаалах ЮНЕСКО-ийн конвенцийн үзэл санааны дагуу соёлын биет бус өв, түүний тээгчийг судлан тогтоох, бүртгэх, баримтжуулах, хадгалж хамгаалах, өвлүүлэн хөгжүүлэх, өв тээгч авъяастнуудад дэмжлэг тусалцаа үзүүлэх, урамшуулах үйл ажиллагааг зохицуулах зорилгоор БСШУ-ны сайдын 2009 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 414 дүгээр тушаалаар “Соёлын биет бус өв, түүнийг тээгчийг тогтоох, бүртгэх журам” батлагдсан.

Уг тушаалыг хэрэгжүүлэн Соёлын өвийн төвөөс аймаг, хотын Засаг даргын тамгын газар, Боловсрол, соёлын газарт, соёлын биет бус өв, түүнийг тээгчийг тогтоох салбар зөвлөл байгуулах, биет бус өвийн тооллого явуулах, анхан шатны бүртгэл мэдээлэл бүрдүүлэх асуудлаар албан бичиг илгээж, салбар зөвлөлийн дүрмийн төсөл, ажиллах журам, соёлын биет бус өвийн бүртгэл-мэдээллийн холбогдолтой маягт, судалгааг боловсруулан хүргүүлсэн болно.

Сайдын тушаалаар батлагдсан журмын дагуу аймаг, нийслэлийн Соёл, урлагийн газрын дэргэд Соёлын биет бус өв, түүний тээгчийг тогтоох салбар зөвлөлүүд байгуулагдсан. Биет бус өв, түүний өвлөгчийг тогтоохдоо судлаачдын санал, орон нутгийн төр, захиргаа, соёлын бодлого, сонголтоор нэр заан тогтоохын зэрэгцээ уг ажилд иргэд олон нийтийн оролцоог хангах үүднээс өв тээгч хувь хүн, хамт олны өргөдлийг хүлээн авч, энэ тухай төв, орон нутгийн мэдээллийн хэрэгслэл, телевизээр сурталчлав.

Сум, дүүрэг соёлын биет бус өвийн анхан шатны бүртгэл, тооллогыг 2010 оны нэгдүгээр улиралд хийж, дүнгээ аймаг, нийслэлийн салбар зөвлөлд ирүүлсэн бөгөөд аймаг, нийслэлээс нэгтгэн ирүүлсэн бүртгэл, жагсаалтыг нэгтгэн боловсруулж, 2010 оны 10 сарын 30-ны өдрөөр тасалбар болгон дүгнэв.

Бүртгэл, тооллогод нийслэлийн найман дүүрэг, 21 аймгийн 269 сумын нийт 3314 өвлөгчийг хамруулсан байна. Улсын хэмжээнд анх удаа явагдаж буй соёлын биет бус өв, түүний өвлөгчийг судлан тогтоох, бүртгэл судалгааны дүнгээс орон нутгийн соёлын байгууллага, мэргэжилтнүүд эрхэлсэн ажилдаа хэрхэн хандаж, хүлээсэн үүргээ хэрхэн


биелүүлж буй нь харагдаж байна. Анхан шатны бүртгэл тооллогод Говьсүмбэр, Дорнод, Дундговь, Завхан, Увс, Ховд, Хэнтий аймаг нийт сумдаа, нийслэлийн Соёл, урлагийн газар дүүргүүдээ бүрэн хамруулж холбогдох жагсаалт, судалгааг ирүүлсэн бол уг ажилд Сэлэнгэ, Орхон, Сүхбаатар, Булган, Говь-Алтай аймаг сумдынхаа 70 хүрэхгүй хувийг хамруулжээ.

Монгол улсын хэмжээнд 325 сум буйгаас 229 сум соёлын биет бус өв, түүний тээгчийн анхан шатны бүртгэл хийж, жагсаалт, судалгаагаа ирүүлсэн дүнтэй байна. Энэ нь нийт сумдын 70,5% хувийг хамарсан үзүүлэлт юм.

Үүнээс үзэхэд аймаг орон нутагт, ялангуяа сумдад уг ажлын зорилго, ач холбогдолыг дутуу ойлгож, урьд өмнө гаргасан алаг цоог мэдээ, судалгааг он сарыг нь өөрчлөх төдийгөөр аргацаан илгээх, Соёлын биет бус өвийн анхан шатны бүртгэл мэдээллийг бүрдүүлэх ажлыг цалгардуулах дутагдал түгээмэл ажиглагдаж байна. Тэрчлэн аймгийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэс, Боловсрол, соёлын газар хоорондын ажил төрлийн холбоо, харилцан мэдээлэл хангалтгүйн улмаас хүргүүлсэн албан бичиг дарагдах, ажил хохирох байдал зарим аймагт ажиглагдав.

Энэ байдалд дүгнэлт хийж, СББӨ, түүний тээгчийн бүртгэл, тооллогод нийт аймаг, сумдыг бүрэн хамруулж, 2010 оны 3-4 улиралд багтаан улс, аймаг, сумын түвшинд СББӨ-ийн бүртгэл мэдээллийн сангийн үйл ажиллагааг жигдрүүлэх зорилгоор тус хэлтсийн ажилтнууд Архангай, Завхан, Хөвсгөл, Булган, Орхон, Өвөрхангай, Баянхонгор, Өмнөговь, Дундговь, Ховд, Баян-Өлгий, Увс, Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Говьсүмбэр аймгуудад шалган зааварлах, арга зүйн зөвлөлгөө өгөх чиглэлээр ажиллав.

Соёлын биет бус өв, түүний өвлөгчийг тогтоох улсын нэгдсэн бүртгэл тооллогын дүнг Үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, СББӨ-ийг ур чадварын өндөр төвшинд эзэмшсэн билиг авъяастны улсын жагсаалтад 35 авъяастныг уг хурлаар батлуулан батламж олгох саналыг БСШУЯ-д оруулж “Жагсаалт батлах тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2003 оны 432 дугаар тушаалын хавсралтад нэмж бүртгэн, батламж олгох шийдвэр 2010 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн “Жагсаалтад нэмэлт оруулах тухай” 546 дугаар тушаал батлагдан гарсан.



## **2.4 Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн төрөл зүйл болох цуур, товшуур, тууль, бий биелгээг хойч үед өвлүүлэх шавь сургалтын бэлтгэл ажлыг хангах:**

### *Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийг хойч үед өвлүүлэх шавь сургалт:*

Ард түмний билэг авъяас, мэдлэг туршлага, эрдэм ухаан, ур чадварын илэрхийлэл болж, биет бусаар өвлөгдөн үеэс үед уламжлагдаж ирсэн оюуны соёлын үнэт зүйлсийг соёлын биет бус өв гэдэг. Нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан монголчууд аман зохиол, язгуур урлаг, гар урлал, ёс заншил, зан үйл, эрдэм ухааны арвин баялаг өв уламжлалтай.

Гэвч нийгмийн амьдралд гарч буй өнөөгийн эрчимтэй өөрчлөлт, даяаршил, хотжилт, суурин соёл иргэншлийн нөлөөгөөр соёлын биет бус өвийн төрөл зүйлүүд мартагдаж гээгдэх, уламжлалт зан үйл, ёс заншил алдрах хандлага улам бүр мэдрэгдэх болов. Ийм нөхцөлд устах аюулд учраад байгаа соёлын биет бус өвийг яаралтай хамгаалах арга хэрэгслийг олж тогтоон цаг алдалгүй хэрэгжүүлэх нь тулгамдсан зорилт болж байна.

Устах аюулд учраад буй соёлын биет бус өвийг хамгаалах хамгийн гол арга бол тухайн өвийн төрөл зүйлийг хойч үед өвлүүлж, сэргээн амилуулах, оршин тогтнох чадварыг хангах явдал юм. Хойч үед өвлүүлэх сургалтыг тухайн төрөл зүйлийн онцлог тал, заах багшийн арга зүй, суралцах шавийн нас, авъяас, сургалт явуулах орчин нөхцөлд нийцүүлэн өөр өөр, арга хэлбэрээр зохион явуулах шаардлагатай. Үүнд:

1. Айл саахалтын ба ураг төрлийн хүмүүсээс авъяас сонирхолтой цөөн хүнийг сонгон авч биеэр үлгэрлэн үзүүлэх, дагалдуулан сургах замаар эзэмшсэн эрдмээ өвлүүлдэг Шавь сургалт (Apprenticeship training) буюу гэрийн уламжлалт сургалт
2. Соёлын төв, сургууль, цэцэрлэг, албан байгууллагыг түшиглэн явуулах төвлөрсөн сургалт (Centralized training)
3. Урьдчилан товлосон хуваарь, графикайн дагуу хэд хэдэн сумдад тухайн сургалтыг ээлж дараатай зохион байгуулах явуулын сургалт (Mobile training)

Харин энэ удаагийн сургалтын хэлбэр нь шавь сургалт буюу гэрийн уламжлалт сургалт байх нь илүү зохимжтой гэж үзэж, зохион байгуулсан. Тухайн өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшсэн бөгөөд өсвөрийн авъяастныг сургах дадлага туршлага бүхий хүмүүсийг сонгож, сургагч багшаар ажиллуулах нь уг сургалтыг амжилттай зохион явуулах гол нөхцөл гэж үзлээ.

Сургагч багшийг сонгон тогтоохдоо тухайн дэг сургууль, арга барилыг бүс нутагтаа төлөөлж чадах билиг авъяастныг судлан олж урамшил, үүрэг хариуцлагын тогтолцоонд хамруулах замаар шийдвэрлэсэн. Шавь сургалт явуулсан багш нарын жагсаалт:

1. Ховд аймгийн Үенч сумын малчин Х.Ходгой (Сариг тэх наадуулж товшуураар хөгжимдөх өвөрмөц урлагийн үзүүлбэрийг өвлөн үлдсэн сүүлчийн төлөөлөгч)
2. Өвөрхангай аймгийн Сант сумын малчин Н.Дорж (Халх найрын уртын дуу, Морь, Бөхийн цол дуудах зан үйл, уламжлалыг өвлөсөн авъяастан)
3. Хөвсгөл аймгийн Түнэл сумын 4-р багийн малчин Н.Мягмаржав (Хануур, хатгуурын аргаар малын өвчин эмгэгийг анагаах эрдэм ухааныг уламжлан эзэмшсэн ур чадвартан)
4. Дундговь аймгийн Дэрэн сумын малчин Г.Дадьсүрэн (Боржигин, Төв халх уртын дууны нэрт төлөөлөгч)
5. Сэлэнгэ аймгийн Шаамар сум, Дулаанхан баг Г.Сүхбаатар (Монгол эвэр нум, сумын уламжлалт урлалын нэрт төлөөлөгч)

6. Өмнөговь аймгийн Даланзадгад сум Л.Мөнхбаяр (Морин хуурын заах арга зүйг төгс эзэмшсэн туршлагатай хуурч, хуурын багш)
7. Улаанбаатар хот, бурхан зураач Н.Дөлгөөн (Бурханы шашны цам бүжгийн баг, өмсгөл зүүсгэлийг урлах ур чадварыг эзэмшсэн зураач, шуумалч /багбон/)
8. Баянхонгор аймгийн Баянлаг сумын малчин Д.Адъяа (Малын уриа дуудлага, төл авахуулах уламжлалт аялгуу, зан үйлийг өвлөн эзэмшсэн авъяастан)
9. Өмнөговь аймгийн Даланзадгад сум, лимбэч, хуурч, Ө.Батжаргал (Лимбэний битүү амьсгааны урлагийг эзэмшсэн авъяастан)

## **2.5 Цамын зан үйлийг хүн төрлөхтний соёлын биет бус өвийн төлөөллийн бүртгэлд тодорхойлох, холбогдох хэрэглэгдэхүүнийг бүрдүүлэх**

*Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгүүлэхээр нэр дэвшүүлэх төрөл зүйлийн баримт бичгийг боловсруулах:*

ЮНЕСКО-гоос “Монгол цуур”, “Монголын уламжлалт бүжиг-бии биелгээ”-г Яаралтай хамгаалах шаардлагатай Соёлын биет бус өвийн дэлхийн жагсаалт”-нд бүртгэн тунхагласан Батламж бичгийг гардан авах ёслолын ажиллагааг 2010 оны 5 дугаар сарын 24-нд Соёлын олон төрөл зүйлийг хамгаалах олон улсын өдрийг тохиолдуулан зохион байгуулахад тус хэлтэс голлох үүрэг гүйцэтгэв. Мөн Монголын Үндэсний музейтэй хамтран “Дэлхийд данстай Монгол өв” үзэсгэлэн, “Монгол тууль”, “Цуур”, “Бии биелгээ”-г сурталчлах өдөрлөг зохин байгуулсан.

Соёлын биет бус өвийг хамгаалах ЮНЕСКО-гийн конвенцийн заалтын дагуу “Хүн төрөлхтний болон Үндэсний төлөөллийн бүртгэлд орох биет бус өвийн жагсаалт”, “Яаралтай хамгаалах шаардлагатай биет бус өвийн үндэсний жагсаалт”-ыг шинэчлэн төлөвлөж Соёл урлагийн бодлогын газарт оруулсан нь, БСШУ-ны сайдын 2010 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 92 дугаар тушаалаар батлагдав.

БСШУ-ны сайдын тушаалаар батлагдсан ажлын хэсгээс “Соёлын биет бус өвийг хамгаалах тухай” Конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ЮНЕСКО-гийн “Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалт”, “Соёлын биет бус өвийн төрөлхтний төлөөллийн жагсаалт”-д бүртгүүлэхэд Монголын соёлын биет бус өвийн дараах төрөл зүйлсийн нэрийг дэвшүүлж, холбогдох баримт бичиг, гэрэл зураг, баримтат кино, дуу, дүрс бичлэгийн хэрэглэгдэхүүнийг бэлтгэхэд арга зүйн талаас нь хариуцаж ажиллав. Үүнд:

- “Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалт”-д бүртгүүлэхээр нэр дэвшүүлж, холбогдох тодорхойлолт хэрэглэгдэхүүнийг өргөн барьсан монгол өв:
  1. Монголын цагаан сарын уламжлалт зан үйл (2010)
  2. Монгол бөө мөргөлийн уламжлал, зан үйл (2010)
  3. Эсгий хийх уламжлалт арга, зан үйл (2010)
  4. Монгол уран хатгамал (2010)
  5. Монгол шатрын уламжлал, урлах арга (2010)
- “Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн жагсаалт”-д бүртгүүлэхээр нэр дэвшүүлж, холбогдох тодорхойлолт хэрэглэгдэхүүнийг өргөн барьсан монгол өв:
  1. Төл авахуулах уламжлалт зан үйл (2010)
  2. Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл (2010)
  3. Монгол цам (2010)
  4. Монгол хувцасны уламжлалт урлал (2010)

5. Монгол уран бичлэг (2010)
6. Уул овоо тахих монгол зан үйл (2010)
7. Онъсон тоглоомын уламжлалт төрлүүд (2010)
8. Лимбэ бишгүүрийн битүү амьсгаа (2010)
9. Монгол жангар (2010)
10. Монгол уран нугаралт (2010)

Үр дүнгийн гэрээнд тусгагдаагүй хийгдсэн ажлууд:

Соёлын биет бус өв, түүний өвлөгчийг тогтоох улсын нэгдсэн бүртгэл тооллогын дүнг Үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, СББӨ-ийг ур чадварын өндөр төвшинд эзэмшсэн билиг авъяастны улсын жагсаалтад 35 авъяастныг уг хурлаар батлуулан төрийн хамгаалалтад авах саналыг БСШУЯ-д оруулж “Жагсаалт батлах тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2003 оны 432 дугаар тушаалын хавсралтад нэмж бүртгэн, батламж олгох шийдвэр гарсан болно.

“Соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийн бүртгэл тооллогыг боловсронгуй болгох, соёлын биет бус өвийг хамгаалах арга зам” сэдвээр төв, хөдөөгийн соёлын ажилтан, ардын авъяастан, иргэдээс авах санал, асуулга, судалгаанд нийт 115 хүнийг хамруулав. Уг судалгааг нэгтгэн, санал, дүгнэлтийг боловсруулан дүгнэж, аймаг, нийслэлийн холбогдох ажилтнуудад танилцуулав.

2010 оны 5 дугаар сард аймаг, нийслэлийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэс, Боловсрол, соёлын газрын соёл хариуцсан мэргэжилтнүүдэд, 2010 оны 10 дугаар сарын 25-27-нд төв, орон нутгийн музейн бүртгэл-мэдээллийн санч нарт соёлын биет бус өв, түүний тээгчдийн тооллого явуулах, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх асуудлаар, тус бүр 2 цагийн хичээл зааж, холбогдох аргачлал, зөвлөмжийг өгсөн болно.

Монгол улсын хүн амын талаас илүү хувь нь амьдарч буй Улаанбаатар хотод СББӨ, түүнийг өвлөгчдийн бүртгэл, тооллогыг үнэн зөв, үр нөлөөтэй явуулахад тус дэм үзүүлэх зорилгоор тус хэлтэс, нийслэлийн Соёл урлагийн газартай хамтран хороодын нийгмийн ажилтнуудын дунд соёлын биет бус өв, түүнийг хамгаалах арга зам, бүртгэн баримтжуулах арга зүй сэдвээр Сүхбаатар, Сонгинохайрхан, Баянгол, Чингэлтэй, Хан-Уул дүүрэгт сургалт зохиов.

2010 оны 12 дугаар сарын 10-11-нд “Монгол Улсын төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай Соёлын биет бус өвийн үндэсний жагсаалт, бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх” төслийн хүрээнд Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс, Нийслэлийн соёл урлагийн газартай хамтран “Соёлын биет бус өвийг хамгаалах тулгамдсан асуудлууд” сэдэвт үндэсний симпозиум, семинарыг зохион байгуулав. Энэхүү симпозиум, семинарт 21 аймгийн музейн захирал, Боловсрол, соёлын газрын соёл хариуцсан мэргэжилтэн, Нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын тамгын газрын соёл хариуцсан мэргэжилтэн нар хамрагдсан.

Соёлын биет бус өв, түүний өвлөн уламжлагчийг судлан тогтоох, бүртгэн баримтжуулах, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдох заавар, зөвлөмж, аргачлал хомс байгааг харгалзан “Соёлын биет бус өвийг бүртгэн баримтжуулах, бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх арга зүй” гарын авлагыг албан хэрэгцээнд зориулан эмхэтгэн гаргаж оролцсон соёлын мэргэжилтнүүдээр дамжуулан нийт сумдын тоогоор хүргүүлсэн болно. Уг гарын авлагт Монгол Улсын соёлын тухай хууль тогтоомж, СББӨ, түүний өвлөгчийг бүртгэх “Монгол улсын соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийн бүртгэл” /2010 оны 12 дугаар сарын 08-ны өдөр шинэчлэн батлагдсан/, ЮНЕСКО-ийн Конвенцууд, Соёлын биет бус өв, түүнийг өвлөгчийг тогтоох

үндэсний зөвлөлийн дүрэм, Соёлын биет бус өв, түүнийг өвлөгчийг тогтоох салбар зөвлөлийн дүрэм, Монгол Улсын соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэл зэрэг СББӨ-ийн холбогдолтой мэдээллүүдийг багтаасан учир гарын авлага нь орон нутгийн соёлын ажилтнуудын ажилд ихээхэн тус дэм болно гэдэгт итгэлтэй байна.

Уг семинарт Боловсрол, соёл шинжлэх ухааны яамны Соёл, урлагийн бодлогын газрын дарга Б.Наранзун, ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссын ерөнхий нарийн бичгийн дарга Д.Далайжаргал, МУИС-ийн багш, доктор, профессор С.Дулам, Төрийн хошой шагналт, ардын жүжигчин Н.Жанцанноров, тус төвийн хэлтсийн дарга С.Юндэнбат болон хэлтсийн мэргэжилтнүүд зэрэг 20 гаруй эрдэмтэн, судлаачид соёлын биет бус өвийг бүртгэн баримтжуулах, яаралтай хадгалж хамгаалах, эрхзүйн орчинг боловсронгуй болгох, тулгамдсан асуудлуудын талаар илтэл тавьж, санал солилцсон. Мөн энэхүү 2 өдрийн үйл ажиллагааны дүрс бичлэгийг тоймлон /4 цаг/ DVD-нд, илтгэлийн материалуудыг CD-нд буулган оролцогчдод тараасан.

“Монгол Улсын төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай Соёлын биет бус өвийн үндэсний жагсаалт, бүртгэл- мэдээллийн сан бүрдүүлэх” төслийн хүрээнд ЮНЕСКО-ийн “Монгол Улсын Төлөөллийн болон Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн жагсаалт, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх” төслийн хүрээнд “Монгол Улсын Соёлын биет бус өв” Цомог хэвлэн гаргахад бэлэн болоод байна.

Энэхүү цомогт БСШУ-ны сайдын 2003 оны 432 дугаар тушаалаар “Утга соёлын өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөсөн Монголын билиг авъяастнуудын улсын жагсаалт”-д бүртгэгдсэн авъяастан болон СББӨ, түүний өвлөгчийг тогтоох үндэсний зөвлөлийн саналын дагуу БСШУ-ны сайдын 2010 онд баталсан “СББӨ-ийн “Ховор хосгүй төрөл зүйлийг язгуур хэв шинжээр нь өвлөсөн билиг авъяастны улсын жагсаалт”-д бүртгэгдсэн нийт 100 хүний товч намтар, гэрэл зураг, Монгол Улсаас ЮНЕСКО-гийн Хүн төрөлхний Төлөөллийн болон Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн дэлхийн жагсаалтад бүртгэгдсэн дэлгэрэнгүй танилцуулга, гэрэл зураг, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 03 дугаар сарын 5-ний өдрийн 293 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Соёлын биет бус өвийн Төлөөллийн Үндэсний бүртгэл”, “Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн Үндэсний Бүртгэл”-д бүртгэгдсэн 88 өвийн төрөл зүйлсийн товч танилцуулга, гэрэл зураг багтсан болно.

#### Соёлын биет бус өвийг дуу, дүрс бичлэгээр бүртгэн баримтжуулах:

- 2010 онд төв, хөдөөд соёлын биет бус өвийн түүвэр судалгаа хийж, язгуур урлаг, аман билгийн төрлөөр 50, уламжлалт зан үйлийн чиглэлээр 2, ардын гар урлалын төрлөөр 5, нийт 57 өв тээгч авъяастныг сурвалжлан судлаж, ур чадвар, урын санг дуу, дүрс бичлэгээр баримтжуулав.
- БСШУЯ, Соёл урлагийн хороо, Завхан аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран 2010 оны 10 дугаар сарын 07-ноос 09-нд Улиастайд зохион байгуулсан “Баруун бүсийн уртын дууны наадам”-ын үйл ажиллагааг дуу, дүрс бичлэгээр баримтжуулж, Ховд, Завхан, Говь-Алтай аймгийн уртын дуучид, хуурчид, ардын авъяастнуудын дунд “Уртын дууны уламжлалт өвийг хамгаалах арга зам” сэдвээр ярилцлага зохион байгуулахад оролцов.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, Ховд аймгийн Зэрэг сумын засаг даргын газар хамтран 2010 оны 10 дугаар сарын 08-наас 10-нд зохион байгуулсан “Захчин урт дууны наадам”-ыг дуу, дүрс бичлэгээр баримтжуулав.
- 2010 оны 12 дугаар сарын 04-05-ны өдрүүдэд БСШУЯ, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн хороо, Монголын язгуур бий биелгээ

өвлүүлэх холбоо, Монголын бүжгийн урлагийн зөвлөл, Монгол ардын язгуур урлагийн Бий-биелэг холбоо, “Өв эрдэнэ” Бий биелгээ шавь сургалтын төв, Соёлын өвийн төв хамтран Улсын Филармоний байранд зохион байгуулсан “Биеэр мэтгэсэн угалз” бий биелгээний уралдааныг дуу, дүрс бичлэгээр баримтжуулав.

- 2010 оны 12 дугаар сарын 10-11-нд Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний комисс, Нийслэлийн соёл урлагийн газартай хамтран Соёлын өвийн төвийн биет бус өвийг хамгаалах хэлтсээс зохион байгуулсан “Соёлын биет бус өвийг хамгаалах тулгамдсан асуудлууд” сэдэвт үндэсний симпозиум, семинарыг дуу, дүрс бичлэгээр баримтжуулав.

### “Соёлын биет бус өвийг хамгаалах тулгамдсан асуудлууд” сэдэвт сургалт симпозиум

“Соёлын биет бус өв, түүний өвлөн уламжлагчийг судлан тогтоох, бүртгэн баримтжуулах, бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх”, “Монгол Улсын Төлөөллийн болон Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийг хамгаалах” ажлын хүрээнд “Соёлын биет бус өвийг хамгаалах тулгамдсан асуудлууд” сэдэвт симпозиум, семинарыг 2010 оны 12 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд Соёлын өвийн төв, ЮНЕСКО-ийн МҮК, Нийслэлийн соёл урлагийн газартай хамтран амжилттай зохион байгууллаа. Уг симпозиум, семинарт 21 аймгийн Боловсрол соёлын газрын мэргэжилтэн, музейн захирал, Нийслэлийн 9 дүүргийн соёл хариуцсан мэргэжилтнүүд хамрагдан оролцсон.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Соёлын биет бус өв, түүний өвлөн уламжлагчийг судлан тогтоох, бүртгэн баримтжуулах, бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг цаашид улам боловсронгуй болгох, үндэс суурийг тавих нь нэн чухал зорилт болж байна. Соёлын биет бус өв, түүний өвлөн уламжлагчийг судлан тогтоох, бүртгэн баримтжуулах, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдох заавар, зөвлөмж, аргачлал хомс байгааг харгалзан “Соёлын биет бус өвийг бүртгэн баримтжуулах, бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх арга зүй” гарын авлагыг албан хэрэгцээнд зориулан эмхэтгэн гаргаж оролцсон соёлын мэргэжилтнүүдээр дамжуулан нийт сумдын тоогоор хүргүүлсэн болно. Уг гарын авлагт Монгол Улсын соёлын тухай хууль тогтоомж, СББӨ, түүний өвлөгчийг бүртгэх “Монгол улсын соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийн бүртгэл” /2010 оны 12 дугаар сарын 08-ны өдөр шинэчлэн батлагдсан/, ЮНЕСКО-ийн Конвенцууд, Соёлын биет бус өв, түүнийг өвлөгчийг тогтоох үндэсний зөвлөлийн дүрэм, Соёлын биет бус өв, түүнийг өвлөгчийг тогтоох салбар зөвлөлийн дүрэм, Монгол Улсын соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэл зэрэг СББӨ-ийн холбогдолтой мэдээллүүдийг багтаав.

Мөн энэхүү симпозиум, семинарт эрдэмтэн судлаач, холбогдох мэргэжилтнүүд болон БСШУЯ-ны Соёл, урлагийн бодлогын газрын дарга мэргэжилтнүүд бүрэн бүрэлдхүүнээрээ оролцон дараах сэдвүүдээр илтгэл тавьж санал бодлоо солилцсон нь оролцогчдын хувьд ихээхэн ач холбогдолтой болж өнгөрсөн.

## **БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АНГИ-3. ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ**

### **3.1 Улс, аймгийн 12 музейн 121 ширхэг үзмэрийг бэхжүүлэх, сэргээн засварлах:**

2010 онд музейнүүдээс ирүүлсэн захиалгын дагуу Монголын үндэсний музей, Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей, Чойжин ламын сүм музей, Уран зургийн галерей, Баянхонгор, Дундговь, Хөвсгөл, Сэлэнгэ, Өмнөговь, Орхон, Төв,



Хэнтий аймгийн музей зэрэг 12 музейн 124 үзмэрийн сэргээн засварлалтыг хийж гүйцэтгэв.

Д/д	Музейн нэрс	Уран зураг	Танка зураг	Даавуу зөөлөн эдлэл	Метал эдлэл	Сийлбэр баримал	Цаас	Археологийн олдвор	Нийт үзмэр
1	Баянхонгор аймгийн музей		4		5		1		10
2	Дүрслэх урлагийн музей			7					7
3	Дундговь аймгийн музей	1	2	2	2	3			10
4	Төв аймгийн музей	1	4	2		5			12
5	Сэлэнгэ аймгийн музей	5							5
6	Уран зургийн галерей	6		2		1	4		13
7	Хөвсгөл аймгийн музей				1				1
8	Орхон аймгийн музей		1	1		1			3
9	Монголын үндэсний музей			7				24	31
10	Өмнөговь аймгийн музей		1		9				10
11	Чойжин ламын сүм музей		17		1	1			19
12	Хэнтий аймгийн музей				1	1			2
13	Дорноговь аймгийн музей			1					1
	Нийт үзмэр	13	29	22	19	12	5	24	<b>124</b>

Сэргээн засварласан байдлаас тодотговол: Хөвсгөл аймгийн музейн томоохон хэмжээний зэс хөөмөл Мэгжид Жанрайсиг бурхан (өндөр 145 см) бүх залгаасаараа салж гэмтсэнийг засаж, бурхны титэм, мутар, мутрын бүх барьц, бад суурийг нөхөн шинээр орлуулан хийж сэргээлээ. Уран зургийн галерейн утаа тортогийн бохирдол болсон 50 гаруй уран зураг, “Баянхонгорын дагина” (200x130 см), “Өнөөгийн жавхаа” (260x185 см) зээгт наамал бүтээлүүдийг сэргээн засварласан. Хэнтий аймгийн музейн Таравчимба судрыг хорхой их хэмжээгээр идсэн, чийгний гэмтлээс шалтгаалж хуудас нь хоорондоо наалдсан тул хуудас бүрийг нэг бүрчлэн салгаж цэвэрлэх ажиллагааг хийж дуусган, музейд нь хүлээлгэн өгсөн.

### **3.2 Монголын Уран зургийн галерейн 50 ширхэг уран зургийг утаа тортогний бохирдлоос цэвэрлэх:**

Уран зургийн галерейн сан хөмрөгт гарсан 2 удаагийн (2008 оны долоодугаар сарын нэгний өдрийн үймээн болон 2009 оны тавдугаар сарын 19-ний үүрээр гарсан

гал түймэр) гал түймэрт өртсөн уран зургийг сэргээн засварлах, цэвэрлэх ажлуудыг үргэлжлүүлэн хийж гүйцэтгэлээ. 2010 онд галын утаа тортогт бохирдож, усанд норж гэмтсэн 50 уран зураг цэвэрлэн тус галерейд хүлээлгэж өгсөн. .

### **3.3 Аялал жуулчлалын бүсэд хамрагдсан 6 газар танилцуулга самбар хийлгүүлэх:**

“Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах үндэсний хөтөлбөр”-т заагдсан хөдөө хээр ил задгай газар орших дурсгалт газруудын дэргэд байрлуулах танилцуулга самбар хийлгүүлэх ажлыг зохион байгуулан ажиллалаа.

Засгийн газрын “Бараа, үйлчилгээ худалдан авах журам”-ын дагуу энэ оны 1 дүгээр улиралд самбар хийлгүүлэх ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах хязгаарлагдмал тендерийг зарлан явуулж, уг тендерт “Бодь-буян” ХХК сонгон шалгарсан. Тус компанитай 2010 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн №2010/01 тоот ажлын гэрээ байгуулан, Сүхбаатар аймагт орших 4 дурсгалт газар, Хэнтий аймгийн 1 дурсгалт газар, Улаанбаатар хотын Их тэнгэрийн аманд байрлуулах зэрэг нийт 6 танилцуулга самбар хийлгүүлсэн.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын танилцуулга самбар нь улсын хэмжээнд нэгдсэн нэг загвараар, 1.5 м-ийн өндөртэй, 2.2 м-ийн өргөн цайвар цагаан боржин чулуугаар хийгдэж байгаа юм. Самбарын нүүрэн талын хар өнгийн гантиган хавтан дээр дурсгалын талаарх товч мэдээллийг монгол, англи хэлээр сийлж бичсэн бөгөөд монгол орны газрын зураг дээр тухайн үл хөдлөх дурсгалын байршлыг тэмдэглэн заасан.

Танилцуулга чулуун самбарыг 2010 оны 5 болон 8 дугаар сард дээрх газруудад нь аваачиж байрлуулсан болно.

### **3.4 “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр”-ийн 7.5, 7.3-4-т заасан:**

*- Хэнтий аймгийн Батширээт сумын Рашаан хадны дурсгал, мөн аймгийн Баянхутаг сумын Сэрвэн хаалганы дурсгалыг авран хамгаалах, бэхжүүлэх, сэргээн засварлах*

Хэнтий аймгийн Батширээт сумын Рашаан хадны дурсгал, мөн аймгийн Баянхутаг сумын Сэрвэн хаалганы дурсгалыг авран хамгаалах, бэхжүүлэх, сэргээн засварлахад дурсгалуудын өнөөгийн гэмтэл бохирдол, байгаль цаг агаарын нөлөөллийг судлахаар 2009 оны 8 дугаар сарын 19-ноос 14 хоногийн хугацаанд, дурсгалуудын чулууны бат бөх чанар, сийрэгжилтийг нарийн тодорхойлж, ижил төрлийн гэмтэлтэй чулууллаг дээр бэхжүүлэлт, хамгаалалтын туршилтын ажлыг 2010 оны 8 дугаар сарын 19-нөөс 28-ний хооронд Япон улсын Токио хотын соёлын өвийг хамгаалах судалгааны хүрээлэн, Нара хотын соёлын өвийг хамгаалах судалгааны хүрээлэнтэй тус тус хамтран ажиллалаа.

2009 оны дээрх дурсгалуудад бичигдсэн бичиг үсгийн дурсгалуудыг бүртгэл баримтжуулах мэдээлэлийн үйл ажиллагаа, дурсгалын өнөөгийн нөхцөл байдал гэмтлийг тодорхойлох хамгаалах үйл ажиллагаа гэсэн 2 үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулсан. Энэ жилийн судалгааны ажил өмнөх жилийн дурсгалын гэмтлийг тодорхойлох судалгааны ажлыг үргэжлүүлж, чулууг бэхжүүлж хамгаалах туршилтын ажиллагааг эхлүүлэх зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Чулууны гадаргуйн цууралт ан цав, хууралт,
2. Чулууны гадаргуйн дулааны хэм, чийгшлийг тодорхойлох хэмжилт,

3. Үсгийн ховил хонхорхой хэсгүүдэд үлдсэн улаан будгийн ул мөр үлдэцийг тодорхойлох;
4. Биологийн бохирдол;
5. Механик гэмтэл;
6. Дээж авах гэсэн чиглэлийн хүрээнд ажилласан.

Энэ чухал 2 дурсгал нь далайн төвшинөөс 1132 м-ийн өндөрт орших бөгөөд олон зууны туршид төв азийн хатуу ширүүн эрс тэс цаг агаарын өөрчлөлт ихтэй уур амьсгал, нар салхи, ус чийг, байгалийн нөлөөлөлд автсаар ирсэн. Өдгөө бичээс бүхий хадны нийт гадаргуйд сийрэгжилт, хагарал, ан цав ихээр үүссэн байгаа нь нүдээр харахад илт мэдрэгдэх ба ялангуяа бичээс бүхий нүүрэн талын талбайд, үеэр хууларч хөндийрэх, зарим хэсэгт бичээстэй байсан гэх ор мөр мэдэгдэхээргүй болтлоо арилж устсан байна. Энэ нь анх чулууны гадаргуйд бичээсийг сийлбэрлэн цохиж бүтээх явцад бичээсийн гадаргуйд үүссэн тодорхой хэмжээний доргилтын нөлөөлөлөөр үсэг болон үсгийн ойр орчмын талбайд чулууллаг бүрдүүлэгч кварц, биотит, хээрийн жонш өөр бусад эрдэс нэгдлүүдийн хоорондын барьцалдуулах холбоос нь тодорхой хэмжээгээр суларч хэврэгшсэн байх магадлалтай юм. Үүнээс шалтгаалж бичээс бүхий чулууны гадаргуйн хэсгүүд бусад бичээсгүй гадаргуйн хэсгүүдтэй харцуулахад, илүү богино хугацаанд сайрч хуурах нөхцөл бүрдсэн байх талтай.

Ялангуяа бичээсийн гадаргуйд хонхор овгор хэсгүүд илүү ихээр үүсэж байгаа нь эрдэс нэгдлүүдийн хоорондын барьцалдуулах холбоосын суларч хөндийрсөн зай завсаруудаар салхи үлээх, чулууны гадарга дээр тогтсон борооны ус цас, мөс нь хайлж эрдэс нэгдлүүдийн зай завсраар урсан шингэж, хүйтэн үед хөлдөх байдлаар тэлэлт үүсгэх нь хуурах сайрч, унах үйл явцад нөлөөлж байна. (Ажлын дэлгэрэнгүй тайлан Соёлын өвийн төвд хадгалагдаж байгаа)

Ажлын үеэр цуглуулсан дурсгалуудын чулууллагын дээжүүдийн туршилт судалгааны ажлыг хэлтсийн дарга С.Чинзориг Япон улсад очиж 2010 оны 12 дугаар сарын 12-ноос 25-нд хамтран хийж гүйцэтгэсэн ба үр дүнг нь 2011 оны эхээр тайлагнах юм.

### **3.5 “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр”-ийн дагуу:**

#### *Дурсгалт газруудад танилцуулгын чулуун самбар байрлуулсан талаар:*

2007 оны Монгол Улсын Засгийн газрын 303 дугаар тогтоолоор батлагдсан “Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр”-т тусгагдсаны дагуу дараах дурсгалт газруудад танилцуулга самбарыг байрлуулах ажлыг 2010 оны 5 дугаар сарын 17-наас 27-ыг хүртэл 10 хоногийн хугацаатай гүйцэтгэв.

- Сүхбаатар аймгийн Онгон сумын нутагт орших “Шивээт таван толгойн” дурсгал,
- Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутагт орших “Алтан овооны хүн чулуу”-н дурсгал,
- Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутагт орших “Ламтын хүн чулуу”-н дурсгал,
- Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутагт орших “Хөргийн хөндийн хүн чулуу”-н дурсгалууд,
- Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутагт орших “Аваргын балгас”
- Улаанбаатар хотын Ихтэнгэрийн аманд байрлах зосон зургийн дурсгалын (2010 оны 8 дугаар сард) дэргэд тус тус байрлуулсан.

Уг ажилд тус төвийн мэргэжилтэн Б.Даваацэрэн, сэргээн засварлагч Д.Нямдорж, А.Бат-Эрдэнэ, Ч.Өсөхбаяр нар болон чулуун самбарыг хийх гүйцэтгэгчээр шалгарсан “Бодь буян” ХХК-ний “Бодь буян” ХХК-ны ажилтан Ж.Октябрь, Б.Энхбаатар болон Зүүн бүсийн соёлын улсын хяналтын байцаагч Б.Мангалжав нар оролцов.

Хөдөө хээр, ил задгай орших түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын дэргэд танилцуулга самбар байрлуулах нь аялагч, жуулчдад тухайн дурсгалын талаар үнэн зөв мэдээлэл өгөх, дурсгалыг хамгаалах, сурталчилахад чухал ач холбогдолтой юм.

Үндэсний хөтөлбөрийн энэ онд хийгдэх ажлын төлөвлөгөөнд Хөвсгөл аймгийн Хядагын буган чулуун хөшөө дурсгал хамрагдах байсан ба бид энэ ажлыг 2012 онд Хөвсгөл аймаг руу чиглэсэн ажлын хүрээнд хамруулахаар болсон.

Танилцуулга самбар байрлуулах ажиллагаанд тухайн сум, орон нутгийн удирдлага албаны хүмүүсийг байлцуулж, уг самбарыг хүлээлгэн өглөө.

### **3.6 Баруун бүсийн хадны зургийн хамгаалалтын талаар судалгаа хийх:**

Говь-Алтай аймгийн Цагаан голын хадны зураг, аймгийн музейд буй хүн чулуу, Завхан аймгийн Яруу сумын Яруугийн голын хүн чулуу, Архангай аймгийн Тариат сумын Тээлийн голын буган чулуу, мөн аймгийн Их тамир сумын Тайхар чулуун дурсгалуудад чулуулгийг бүтцээр нь нар салхи, усны нөлөөллөөр хими, физикийн нөлөөллөөр, ургамал, амьтны биологийн нөлөөллөөр, хүний буруутай үйл ажиллагаа гэх мэт чиглэлийн тандалт судалгааг 2010 оны 6 дугаар сарын 25-наас 7 дугаар сарын 5-н хооронд хийж гүйцэтгэсэн. Соёлын өвийн төвийн захиарл Г.Энхбат, сэргээн засварлах хэлтсийн дарга С.Чинзориг, МУ-ын Соёлын гавъяат зүтгэлтэн, химич, чулуу судлаач Г.Гонгоржав нар ажиллав.

Баруун бүсийн дурсгалуудын бүтэц, эвдрэл гэмтлийн талаарх энэхүү судалгаа нь дурсгалыг хамгаалах, бэхжүүлэх, сэргээн засварлалтын ажлын өмнөх үндсэн бэлтгэл ажил болно. Судалгааны баг дурсгал бүр дээр дүгнэлт гарган, тайланг бичив. (Ажлын дэлгэрэнгүй тайлан Соёлын өвийн төвд хадгалагдаж байгаа)

#### **Нэмэлт сэргээн засварлалт хийсэн ажлууд:**

Үндэсний түүхийн музейгээс энэ онд сэргээн засварлах 22 үзмэрээс гадна 18 үзмэр нэмэгдэн ирж сэргээн засварласан.

Нүүдлийн соёл, иргэншлийг судлах олон улсын хүрээлэн, ОХУ-ын Буриадын Монгол-Түвд-Буддын судлалын хүрээлэнгийн хамтарсан судалгааны анги 2009 оны 7 дугаар сард Төв аймгийн Заамар сумын нутаг Шороон бумбагар хэмээх газраас олдсон Түргийн үед холбогдох археологийн олдворуудын 2009 оноос эхлүүлсэн сэргээн засварлалтын ажил АНУ-ын элчин сайдын яамны дэргэдэх “Элчин сайдын нэрэмжит сан”-гийн түүх, соёлын дурсгалыг хамгаалах чиглэлийн хүрээнд олгодог тэтгэлгийн санхүүжилтээр хийгдэж байна.

Өвөрхангай аймгийн Хархорин суманд шинээр байгуулагдаж байгаа “Хархорум музей”-н захиалгаар Архангай, Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэр дээрх зарим чулуун дурсгалуудыг зөөвөрлөн музейд байрлуулах ажлыг 2010 оны 7 дугаар сард, Хархорум хотын туурийн малтлагаас гарсан шатаах зуухын макетийг хийх ажлыг 10 дугаар сарын 28-наас 11 дүгээр сарын 10-ны хооронд хийж гүйцэтгэсэн. (Ажлын дэлгэрэнгүй тайлан Соёлын өвийн төвд хадгалагдаж байгаа)

#### **Ламтын хүн чулуун хөшөөг сэргээн засварласан тухай**

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутагт орших “Ламтын” гэж нэрлэгдэх хоёр хүн чулууны хадгалалт, хамгаалалтыг сайжруулан бэхжүүлэлт, сэргээн засварлалтын ажлыг 2010 оны тавдугаар сарын 01-нээс 09-ний хооронд хийж гүйцэтгэлээ.

XIII-XIV дугаар зууны үед холбогдох энэхүү хүн чулуун хөшөө дурсгал нь Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 175-р тогтоолоор батлагдсан “Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн жагсаалт”-ын “Улсын хамгаалалтад” орсон дурсгал юм.

Хүрээлэн буй орчны нөлөөллөөс шалтгаалан эдгээр хүн чулуун дурсгал нь шувууны сангас, хадны хаг, элс шороо гэх мэт биологийн гаралтай бохирдол нилээд болсон, нэг хүн чулууны толгой нь хүзүүний уг хэсгээрээ хугарчээ. Хүзүүгээрээ хугарсан хэсэг нь он цагийн явцад элэгдэн мөлийж, чулууны гар, хөл, гэх зэрэг хэсгүүдэд нарийн хагарал, цуурал үүсэж зарим жижиг хэсгүүд нь үрэгдэж үгүй болсон байв.

Сэргээн засварлалтаар чулуун дурсгалуудын бохирдлыг механик аргаар цэвэрлэн, нарийн хагарал цууралтыг цаашид нэмж цуурч, хагарахаас хамгаалж бэхжүүлэн, хугарсан хэсгүүдийг нааж засах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Хүн чулууны толгойг эвлүүлэн наахад хөшөө чулуун дурсгалын сэргээн засварлалтад хэрэглэгддэг, зориулалтын зэвэрдэггүй металлыг хугарсан толгойн голд суулган хүчитгэсэн. Эвээрээ нийлж байгаа хэсгүүдийг “Paraloid B72” бэхжүүлэгч бодисоор бэхжүүлсэн ба үүнийг тусгаарлах үе давхарга болгон хүн чулууны толгойг нааж сэргээн засварласан.

Хөшөө чулуунд үүссэн нарийн хагарал, цууралт нь хөшөө чулууны эвдрэл, гэмтэлд хамгийн их нөлөөлдөг. Түүний завсарт тогтсон бороо, цасны ус, мөс хайлах, хөлдөх процессын дүнд цууралт хагарлыг бага, багаар улам бүр тэлж байдаг.

Нарийн хагарал үүссэн хэсгүүдэд бэхжүүлэгч бодис шингээн, хагарлыг цаашид нэмэгдэхээс хамгаалан урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, үрэгдэж үгүй болсон жижиг хэмжээний хэсгүүдэд ижил төрлийн чулуугаар нөхөлт хийн сэргээсэн.

Ажлын явцад Ламтын хүн чулуудаас гадна тус сумын нутагт орших “Хөргийн хөндийн хүн чулуун” дурсгалуудын нөхцөл байдалтай танилцсан бөгөөд уг дурсгалуудад мөн адил хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт хийх шаардлагатай байна.

### **Үр дүнгийн гэрээнд тусгагдаагүй нэмэлт хийгдсэн ажлууд:**

#### **Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар:**

- Төвийн захирал Г.Энхбатын урилгаар БНХАУ-ын Соёлын өвийн академийн орлогч захирал Хоу Вэй Дон, Түүхэн дурсгалт зүйлийн хэрэг эрхлэх газрын хэлтсийн дарга Шү-Янь, Хятадын эзэн хааны ордны сэргээн засварлах хэлтсийн дарга Жан Кэгүй нарын бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид 2010 оны наймдугаар сарын 15-аас 19-ны өдрүүдэд тус соёлын өвийн төвд ажлын зочилсон.

Айлчлалын зорилго нь түүх, соёлын үл хөдлөх дурсгал, сүм хийд дурсгалт уран барилгын сэргээн засварлалтын зарим арга технологитой танилцах, санал солилцох, цаашид хамтран ажиллах чиглэлээ тодорхойлоход чиглэгдсэн юм.

Төлөөлөгчид БСШУЯ-ны Соёл, урлагийн бодлогын газрын дарга Б.Наранзун, Монгол Улс дахь БНХАУ-ын Элчин сайдын яамны Соёлын зөвлөх У Шинь Ин нартай уулзан хамтарч ажиллах талаар санал солилцов.

Цаашид Дорнод аймгийн нутагт орших X зууны үед холбогдох “Хэрлэн барс” хэмээх эртний хотын суварганы үлдэгдэл, мөн аймгийн нутагт орших XVIII зууны үед

холбогдох “Их бурхант” хэмээх чулуун бурханы дурсгалд сэргээн засварлалт, бэхжүүлэлт хийх, мэргэжилтэн солилцох, туршлага судлах, хамтарсан сургалт, дадлагын ажил зохион байгуулах, монгол орны байгаль цаг агаар, орчин нөхцөлд тохирсон сэргээн засварлах арга зүй, технологи боловсруулах зэрэг чиглэлээр хамтран ажиллахаар харилцан тохиролцоод байна.

Монгол Улс, БНХАУ соёлын биет бус өвийг хамгаалах салбар дахь хамтын ажиллагааны ажлын хэсгийн анхдугаар уулзалтын талаар:

- Монгол улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Соёлын яам хоорондын “Соёлын биет бус өвийг хамгаалах тухай хамтын ажиллагааны харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн дагуу хоёр улсыг төлөөлсөн ажлын хэсгийн анхны уулзалт-хуралдаан Монгол улсын нийслэл Улаанбаатар хотноо 2010 оны 12 дугаар сарын 14-17-ны өдрүүдэд Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны 117 тоот хурлын танхимд 2010 оны 12 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд зохион байгуулав.

Хуралдаанд Монголын талаас БСШУ-ны сайдын 2010 оны 383 дугаар тушаалаар батлагдсан Соёлын өвийн төвийн захирал Г.Энхбатаар ахлуулсан ажлын хэсэг С.Юндэнбат, Ц.Жаргалсайхан, Б.Баярмаа, П.Дашдорж, Н.Наранцацралт, Л.Мөнхзул, Д.Мөнгөнтуул, Н.Сувд-Эрдэнэ, Г.Долгорсүрэн нар, БНХАУ-ын талаас Соёлын яамны гадаад харилцааны газрын туслах дарга Ян Зи-аар ахлуулсан Ван Ханжие, Ма Шин Дө, Зоү Чи Шан, Бү Хө Чао Лу, Лиу Ян, БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны соёлын зөвлөх Ү Шиньяа, нарийн бичгийн дарга Де Бо нар байлцав.

Уулзалт хуралдаанаар дараах үндсэн зургаан төрлийн зүйлийг хэлэлцэн ярилцаж санал солилцлоо. Үүнд:

1. Хоёр улсаас энэхүү ажилд томилогдон ажиллаж буй ажлын хэсгийн гишүүдийн болон Удирдах хорооны гишүүдийн тухай танилцуулга хийх,
2. Монгол улс, БНХАУ-ын Соёлын биет бус өвийн салбарт хамтран ажиллах Удирдах хорооны ажиллах дүрмийн төслийг монголын талаас боловсруулсныг танилцуулах,
3. ЮНЕСКО-ийн биет бус соёлын өвийг хамгаалах конвенцийн үзэл санааг нэгдсэн байр сууринаас ойлголцох,
4. Соёлын биет бус өвийг хамгаалах хамтын ажиллагаа “Уртын дуу” төслийн талаар ярилцах,
5. Хоёр тал ЮНЕСКО-ийн жагсаалтанд соёлын өвийг дангаар болон эсвэл хамтарч бүртгүүлэх тухай,
6. Хоёр талын эрдэмтэн судлаачдын хамтарсан судалгааны ажил хийх тухай болно.

Төвийн шинэ барилгын ажлын талаар:

- Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн хамгаалах, сэргээн засварлах үндэсний хөтөлбөр”-ийн 7.7.1-д заасан “Соёлын өвийн төвийн зориулалтын барилга барих” ажлыг гүйцэтгэхэд газрын зөвшөөрөл олгох тухай хүсэлтийг Нийслэлийн Засаг даргын тамгын газар болон бусад холбогдох байгууллагууд хүлээн авч, Хан-Уул дүүргийн газрын албанаас тус дүүргийн 10-р хорооны нутаг дэвсгэрт 1 га газрын зөвшөөрлийн олгосон.

Шинээр баригдах барилгад манай байгууллагын үйл ажиллагааны онцлог, мэргэжлийн дагуу шаардагдах техникийн нөхцөл бүхий өрөө тасалгааны зохион байгуулалт, үзүүлэлтийг анхан шатны байдлаар боловсруулан зураг төсөл хийлгүүлэв.

Боловсруулсан төслийн ажлын талаар:

- Манай төвийн үйл ажиллагаанд чухал шаардлагатай зарим нэгэн тоног төхөөрөмжийг олж авах зорилгоор Япон улсын Засгийн газраас олгодог соёлын буцалтгүй тусламжид хамрагдах “Түүх, соёлын дурсгал, соёлын өвийн оношилгоо, судалгааны төхөөрөмж” нэртэй төслийг 2010-2011 оны санхүүгийн жилд хэрэгжих үндсэн нөхцөлтэйгээр 2009 оны хоёрдугаар сард Монгол Улс дахь Япон улсын Элчин сайдын яаманд өргөн барьсан. Төсөл Монгол Улс дахь Япон улсын Элчин Сайдын Яам болон ЖАЙКА-гийн Монгол дахь төлөөлөгчийн газраас дэмжигдэж одоо Япон улсын Засгийн газрын хэмжээнд хэлэлцэгдэж байна.

Төслийн хэлэлцүүлэгийн хүрээнд манай төвийн үйл ажиллагаатай танилцах, төслийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зорилгоор Япон улсын Засгийн газар, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагын дэд дарга Сатоши Хори, мэргэжилтэн Хироюуки Мамияя нар 2010 оны 8 дугаар сарын 31-ний өдрөөс 2010 оны 9 дүгээр сарын 6-ны өдрүүдэд тус төв дээр 7 хоногийн хугацаатай ажилласан. Энэ хугацаанд төвийн үйл ажиллагаатай танилцаж, төслийн хэрэгцээ шаардлагыг судласан ба БСШУЯ-ны Соёл, урлагийн бодлогын газрын дарга Б.Наранзун, Соёлын төвийн захирал Г.Энхбат, Япон улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын дэд дарга Сатоши Хори нар “Түүх, соёлын дурсгал, соёлын өвийн оношилгоо, судалгааны төхөөрөмж” төслийн анхан шатны судалгааны хэлэлцээний тэмдэглэлийг хийсэн.

2011 оны 4 дүгээр сард Япон улсын Засгийн газраас төслийн хариуг эцэслэн шийдвэрлэх бөгөөд энэ хугацаанд монголын талаас дараахи бэлтгэл ажлуудыг хийж гүйцэтгэхээр болсон. Үүнд:

- Соёлын өвийн төвийн шинэ барилга, бүтэц зохион байгуулалтын талаар нарийвчилсан мэдээлэл өгөх,
  - Төслийн жагсаалтанд багтсан модон эдлэл сэргээн засварлах төхөөрөмж PEG tank-г суурилуулах зорилгоор 2008 оны 7 дугаар сарын 1-ний олон нийтийг хамарсан үймээний үеэр галд өртсөн модон эдлэл сэргээн засварлах урланг үйл ажиллагаанд оруулах,
  - Төслийн жагсаалтад багтсан модон эдлэл сэргээн засварлах төхөөрөмж PEG tank-г ажиллуулах нэмэлт цахилгааны эх үүсгэвэр (генераторыг) суурилуулах.
- АНУ-ын Элчин сайдын нэрэмжит сангаас жил бүр соёлын дурсгалыг хамгаалах ажилд олгодог тэтгэлэгт хамрагдах зорилгоор “Шатаж гэмтсэн уран зургийг сэргээн засварлах” нэртэй төслийг 2010 оны 11 дүгээр сард өргөн барьсан. Энэхүү төсөл нь Монгол Улс дахь АНУ-ын Элчин сайдын яамнаас бүрэн дэмжигдэж АНУ-ын Вашингтон хотод хэлэлцэгдэж байна. 2011 оны 5 дугаар сард төслийн хариу эцэслэн шийдвэрлэгдэнэ.

Соёлын өвийн бүртгэлийн маягтыг шинэчлэн боловсруулсан талаар:

Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 6; 7; 8-р зүйлийн заалтыг хэрэгжүүлж, соёлын өвийн улсын бүртгэл-мэдээллийн санд түүх, соёлын хөдлөх

дурсгалыг БСШУ-ны сайдын 2006 оны 56-р тушаалаар батлагдсан “Монгол улсын соёлын өвийн бүртгэл” маягт № 2-ын дагуу, үл хөдлөх дурсгалыг мөн сайдын 2007 оны 348-р тушаалаар батлагдсан “Монгол улсын түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл” маягт №1-ын дагуу тус тус бүртгэж ирсэн.

2008 оноос эхлэн Соёлын өвийн төвийг өргөжүүлж, утга соёлын өвийг бүртгэх, бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх чиг үүрэг нэмэгдсэн ба соёлын биет бус өвийг бүртгэх албан ёсны батлагдсан бүртгэлийн маягт байгаагүй.

Улсын бүртгэл-мэдээллийн санд соёлын биет болон биет бус өвийг бүртгэхэд нэгдсэн нэг стандарт бүхий соёлын өв тус бүрийн онцлогийг тусгасан бүртгэлийн гурван төрлийн бүртгэлийн маягтыг боловсруулан, БСШУЯаманд хүргүүлсэн.

БСШУ-ны сайдын 2010 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 541 дүгээр тушаалаар “Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл”, Монгол Улсын үл хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл” болон “Монгол улсын соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн бүртгэл”-ийн маягтуудыг тус тус баталсан.

#### Судалгаа, сурталчилгааны ажил:

- 2010 оны нэгдүгээр сард 2009 онд үл хөдлөх дурсгалын бүртгэл, тооллого явагдсан Дорнод, Дорноговь аймгийн “Монгол нутаг дахь үл хөдлөх дурсгал” цуврал товхимол хэвлүүлэн улс, аймгийн музей, номын сан, бүх сумдын соёлын төвүүдэд үнэ төлбөргүй тараасан. Мөн 2010 оны 12 дугаар сард Хэнтий аймгийн цомгийн хоёр дахь шинэчилсэн хувилбарыг хэвлэв.
- 2010 оны 12 дугаар сард “Соёлын өвийн мэдээ, мэдээлэл” сэтгүүлийн оны дугаарыг эрхлэн хэвлүүлж, холбогдох газруудад тараах ажлыг хийгээд байна. Сэтгүүлийн дугаарт соёлыг өвийг хадгалж хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, иргэдийн 2010 онд хийгдсэн ажлуудын талаарх мэдээ, материалууд нийтлэгдсэн. Сэтгүүлийг улсын болон аймгийн бүх музей, Улаанбаатар хотын их, дээд сургуулиудын номын сан, зарим эрдэм шинжилгээний хүрээлэн, аймгуудын номын сан, бүх сумдыг соёлыг төвүүдэд тарааж байна.
- 2010 оны 10 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд зохион байгуулсан “Соёлын өвийн бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх нь” сургалтын семинарын үеэр гарын авлага материал хэвлүүлэн, улсын нэгдсэн сүлжээнд хамрагдаж байгаа музей, эрдэм шинжилгээний хүрээлэн, номын сан зэрэг байгууллагын бүртгэл-мэдээллийн сангийн ажлын албан хэрэгцээнд тараав.
- Байгууллагын бүтэц чиг үүрэг нэмэгдсэнтэй уялдуулан [www.monheritage.mn](http://www.monheritage.mn) вэб сайтыг шинэчлэн хийж ашиглалтанд оруулаад байна.

#### Соёлын өвийг судлах, хамгаалах, сэргээн засварлах чиглэлийн мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэх талаар сургалтанд оролцсон талаар:

- Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны харьяа Соёлын өвийн төв, Монголын урлагийн зөвлөл болон АНУ-ын Виллямстауны сэргээн засварлах төвийн хооронд байгуулсан санамж бичиг, мэргэжилтэн солилцох хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн дадлага, туршлага судлах зорилгоор сэргээн засварлагч Д.Нямдорж, А.Мөнгөнцоож нар 2010 оны 3 дугаар сарын 2-ноос 28-ний хооронд 26 хоног Виллямстауны сэргээн засварлах төвд ажилласан.



Тэнд байх хугацаандаа Уран зургийн галерейгээс аваачсан шатсан зургийг сэргээн засварлах ажлыг хамтран хийж, шатсан зургуудыг монголд сэргээн засахад нэн шаардлагатай байгаа техник тоног төхөөрөмжийн судалгааг хийсэн.

Ажлын гүйцэтгэлийн үр дүнг БСШУ-ны сайд, мөн яамны Соёл, урлагийн бодлогын газрын дарга нарт танилцуулсан. (Ажлын дэлгэрэнгүй тайлан Соёлын өвийн төвд хадгалагдаж байгаа)

Мөн энэ оны есдүгээр сарын 3-наас 8-ны хооронд Виллямстауны уран зургийн сэргээн засварлагч Синтия Лук, даавуу зөөлөн эдлэлийн сэргээн засварлагч Алисон Макколский нар манай төвд ирж уран зураг, бөс даавуун эдлэлийг сэргээн засварлахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Энэ үеэр Алисон Макколский манай Соёлын өвийн төв дээр сэргээн засварласан XIII үед холбогдох дээлний даавууны бүтцийн судалгаа болон сэргээн засварлахад хэрэглэгдсэн зарим химийн материалын нөлөөллийн шинжилгээ хийсэн тухайгаа танилцуулсан. Түүний хийсэн шинжилгээний үр дүнгээр дээлийг цэвэрлэхэд хэрэглэсэн угаалгын бодис ямар нэг хэмжээгээр дээлэнд шингэж үлдээгүй, цэвэрлэгээний ажил маш сайн хийгдсэнийг дурдсан байна.

- Туркийн олон улсын хамтын ажиллагааны байгууллага ТИКА-гийн зуучлалын шугамаар Туркийн Станбул хотын Станбулийн Их сургуульд түүх, археологийн олдворыг сэргээн засварлах сургалтанд сэргээн засварлагч С.Чинзориг, Г.Соёл-Эрдэнэ нар 2010 оны 3 дугаар сарын 4-нөөс 4 дүгээр сарын 15-ний хооронд, мөн 7 дугаар сарын 16-наас эхлэн нэг сарын хугацаатай дахин үргэлжлүүлэн суралцсан.
- Биет бус өвийг хамгаалах хэлтсийн мэргэжилтэн У.Сайнбаяр 2010 оны 4-р сарын 01-ээс 6-р сарын 30-ны хооронд Бүгд Найрамдах Солонгос Улсын “Соёлын өвийн үндэсний хүрээлэн”-д дадлагажих сургалтанд хамрагдаж, Солонгосын соёлын биет бус өв, түүнийг хамгаалах систем, эрх зүйн орчин, бүртгэл, баримтжуулалттай танилцаж туршлага судлан судалгаа хийж мэргэжил дээшлүүлсэн.
- Япон улсын Нара хотод 2010 оны 6 дугаар сарын 21-ээс 7 дугаар сарын 1-ний өдрүүдэд зохион байгуулагдсан олон улсын боловсрол, соёл солилцооны хөтөлбөр “Ази-Номхон далайн орнуудын соёлын өвийн удирдлагын сургалт”-д Биет соёлын өвийг хамгаалах хэлтсийн мэргэжилтэн Ц.Цолмон оролцов. Уг сургалт нь ЮНЕСКО-гийн Ази-Номхон Далайн Орнуудын Соёлын Өвийг Хамгаалах Хамтын Ажиллагааны Газраас уламжлал болгон жил бүр зохион байгуулдаг.  
Сургалтанд оролцогчдыг өөрсдийн орны соёлын өвийн хамгаалалд үр дүнтэй бодлого нэвтрүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, лекц, хэлэлцүүлэгээр дамжуулан соёлын өвийн хамгааллын чухал шаардлагатай мэдээллээр хангах, Дэлхийн өвд бүртгүүлэхээр нэр дэвшүүлэх үйл явцыг судлах, соёлын өвийн хамгааллын өнөөгийн нөхцөл байдал болон шинэлэг арга санаачлага, олон улсын хамтын ажиллагааны талаарх мэдээ, мэдээлэл арга туршлага солилцсон сургалт болсон.
- Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Бүгд Найрамдах Солонгос Улсын Соёлын өвийн хорооны хооронд Соёлын өвийн салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг, Бүгд Найрамдах Солонгос Улсын Соёлын өвийг хамгаалах хорооноос ирүүлсэн урилга, Монгол Улсын Боловсрол шинжлэх ухааны сайдын 2010 оны есдүгээр сарын наймны 393 дугаар тушаалийн дагуу Бүгд Найрамдах Солонгос улсад соёлын өвийн хадгалалт хамгаалалт,

менежментийн чиглэлээр 2010 оны есдүгээр сарын 13-наас 17-ны өдрүүдэд томилолт аван ажиллалаа.

Монгол улсын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Соёл, урлагийн бодлогын газрын дарга Б.Наранзун, Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн Б.Баярмаа, БСШУЯ-ны хуулийн зөвлөх С.Мөнхүүлэй, Чойжин ламын сүм музейн захирал Д.Отгонсүрэн, Биет соёлын өвийг хамгаалах хэлтсийн дарга Д.Нарантуяа нар байлаа.

Солонгос улсад байх хугацаанд соёлын өвийг хамгаалах ажлын арга туршлага судлах, дэлхийн өвийн жагсаалтад орсон дурсгалуудын хадгалалт хамгаалалтын байдалтай газар дээр нь танилцаж, Солонгос улсын соёлын өвийг хамгаалах хороотой соёлын өвийг хамгаалах чиглэлээр хамтарч ажиллах талаар санал солилцсон. (Дэлгэрэнгүй тайлан Соёлын өвийн төвд хадгалагдаж байгаа)

- Гёте-Институтийн Монгол дах төлөөлөгчийн газраас 2010 оны есдүгээр сарын 26-аас 10 дугаар сарын 6-нд зохион байгуулсан “Германы номын сан, түүний Дорно азийн номыг хадгалж хамгаалах, хэрэглэх туршлага”, “Хуучин ном, судрыг сэргээн засварлах” гэсэн сургалт семинарт сэргээн засварлагч Б.Мягмарсүрэн оролцов.

Уг сургалтыг Герман улсаас ирсэн мэргэжилтэн хичээлийг удирдан явуулсан ба цаасан баримтат өв төвлөрөн хадгалагдаж байдаг Гандантэгчинлэн хиидийн номын сан, Үндэсний болон хотын номын сан, Архивын ерөнхий газар, Хүүхдийн номын ордон, Соёлын сургууль зэрэг байгууллагууд хамрагдсан.

Сургалтын сэргээн засварлах дадлага ажлыг тус өвийн төв дээр хийж, цаасан баримтат өвийн хуурай цэвэрлэгээ, усны гэмтлийг бууруулах, урагдалтыг холбох, дутагдсан хэсгийг нөхөх, нугаралт хугаралтыг тэнийлгэх, номыг хавтаслах, засварыг арилгах зэрэг сэргээн засварын арга технологийн заасан нь сэргээн засварлагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэхэд чухал үр дүнтэй сургалт болсон.

- Хэнтий аймгийн Батширээт сумын нутагт орших Рашаан хад, мөн аймгийн Баянхутаг сумын нутагт орших Сэрвэн хаалганы дурсгалыг судлах, хамгаалах ажлын хүрээнд тус сэргээн засварлах хэлтсийн дарга С. Чинзориг, Биет соёлын өвийг хамгаалах хэлтсийн программист Б. Алтансүх нар 2010 оны 12 дугаар сарын 12-ноос 26-ний өдрүүдэд Япон улсын Нара-гийн Соёлын өвийн Үндэсний судалгааны хүрээлэн дээр тус хүрээлэнгийн мэргэжилтнүүдтэй хамтарсан туршилт судалгааг ажлыг гүйцэтгэлээ.

Судалгааны ажлын гол зорилго нь Рашаан хад, Сэрвэн хаалганы дурсгалын чулуулагтай ижил төсөөтэй зарим чулуун дээжүүдийг Япон улсад аваачин судлах, чулуун дээжүүд дээр бэхжүүлэлт хийх, мөн соёлын өвийн сэргээн засварлалт, судалгаа шинжилгээ, бүртгэн баримтжуулалтанд ашиглагдаж байгаа зарим нэгэн дэвшилтэт тоног төхөөрөмжийг үзэж судлах, зарим нэгэн тоног төхөөрөмж дээр дадлагажих ажлыг хийсэн.

### **Бусад ажлын талаар:**

- Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас баталсан удирдамжийн дагуу Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Соёл урлагийн хороо, Соёлын өвийн төв хамтран 2007-2008 оны улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллогын мөрөөр явагдсан ажлын гүйцэтгэлийг шалгах зорилгоор энэ оны 5, 6 дугаар сард улсын тооллогоор музейн сан хөмрөгөөс хасаж актлах, шилжүүлэх үзмэрийн асуудлыг шийдвэрлэсэн байдалд шалгалт хийлээ. Шалгалтад Үндэсний музей, Байгалийн

түүхийн музей, Дүрслэх урлагийн музей, Богд хааны ордон музей, Чойжин ламын сүм музей, Уран зургийн галерей, Монгол цэргийн музей, Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сан хамрагдлаа.

Шалгалтын дүнд улсын 5 музейн 1175 дэсийн 1832 ширхэг үзмэрийг актлах, мөн улсын 5 музейн 459 дэсийн 807 ш, орон нутгийн 10 музейн 657 ширхэг үзмэрийг нийт 1464 ширхэг үзмэрийг байгууллагад нь үлдээж, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрийн дагуу арга хэмжээ авах тухай МХЕГ-ын улсын байцаагчийн дүгнэлт гарч шалгалтын дүнг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Газрын дарга нарын зөвлөлийн хурлаар 2010 оны 12 дугаар сарын 9-ны өдөр орлоо. Шалгалтын албан ёсны дүгнэлт Соёлын өвийн улсын нэгдсэн-бүртгэл мэдээллийн санд хадгалагдсан болно.

- Сэлэнгэ аймгийн музейгээс 2010 оны 9 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд зохион байгуулсан “Нийгэм, соёл, шинжлэх ухааны хөгжил-сэлэнгэчүүд” сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд тус төвийн мэргэжилтэн Ш.Энхтуяа, Ж.Насанжаргал нар биет болон биет бус өвийг бүртгэн баримжуулалтын талаар лекц уншлаа.
- Соёлын өвийн зориулалтын барилгын техникийн өгөдлийг бэлтгэн эскез зургийг зуруулж бэлтгэл, ажлыг ханган ажиллалаа.

### **Дүгнэлт:**

БСШУЯ-наас зохион байгуулж буй “Монголын музейн үзмэрүүд” гэрэл зургийн цомог, цахим каталогит орох үзмэрийн үзмэрийн гэрэл зургийг авах, текст тодорхойлолт бэлтгэх, музейн үзмэрийг бүртгэх бүртгэлийн “РСН програмыг шинэчлэх, бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах, монгол улсын соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийн улсын тооллогыг явуулах, бүртгэх, соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлахад 2010 оны бүтээгдэхүүн нийлүүлэлтийн үр дүнгийн гэрээнд тусгагдсан ажлуудыг бүрэн хангаж ажиллалаа.

Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сангаас гаргасан графикийн дагуу жил бүр музейнүүдээс үзмэрийн бүртгэлийг хүлээж авч байна. Гэвч музейнүүд байгууллагынхаа бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх, үзмэрийн бүртгэлээ улсын санд ирүүлэх байдал нь харилцан адилгүй байна.

Музейнүүдээс ирүүлж байгаа бүртгэлийн бүрдүүлэлт дутуу, үзмэр музейд анх орж ирсэн цагаас эхлэн түүний талаарх бүртгэл, мэдээллийг дутуу дулимаг бүрдүүлж ирсэн, судалгаа шинжилгээний ажил тааруу муу байгаагаас үзмэрийн бүртгэл нь тэр бүр шаардлагыг хангаж чадахгүй байна. Үзмэрийн бүртгэн баримтжуулалтад:

- Музейн ажилтнуудын мэргэжил, мэдлэгийн ур чадвар,
- Музейд мэргэжлийн боловсон хүчин дутмаг,
- Тухайн үзмэр музейд орох, хүлээн авсан цагаас эхлэн холбогдох намтар түүх,

уг сурвалж, бүтээсэн буюу холбогдох он цаг тухай судалгаа шинжилгээ ажил дутуу дулимаг хийгдэж явж ирсэн нь бүртгэл бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлж байна.

Монгол музейн шилдэг үзмэрүүдийг хамруулах, баталгаажуулах зорилгоор хийгдэж байгаа “Монголын музейн үзмэрүүд” гэрэл зургийн цомог, цахим каталогийн хэрэглэгдэхүүнийг бэлтгэх ажлын явцад ялангуяа орон нутгийн музейн үүднээс улс, аймгийн музейгээс шилдэг тооцогдох үзмэрүүдийн гэрэл зургийг авах, тодорхойлолтыг бэлтгэх ажлыг гүйцэтгэсэн. Ялангуяа орон нутгийн музейнүүдийн сүүлийн жилүүдэд худалдан авсан гэх үзмэрүүдийн дунд хуурамч дууриамал байж болзлошгүй үзмэрүүд байсаныг хэлэх хэрэгтэй.

Соёлын биет бус өв (СББӨ)-ийг өвлөн тээгчдийн жагсаалт, биет бус өвийн жагсаалт, Соёлын биет бус өвийн Үндэсний төлөөллийн бүртгэлд оруулах өвийн санал, Яаралтай хамгаалах Соёлын биет бус өвийн жагсаалтад оруулах санал, бүртгэлийн дагуу ирүүлэх СББӨ-ийг ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшсэн билэг авъяастны судалгааны ажлын хувьд цаг хугацаа богино, мэргэжил арга зүйн мэдлэг дутмаг байгаа нь орон нутгаас ирүүлсэн баримт бичиг, судалгаанаас харагдаж байна. Тиймээс орон нутаг дахь соёл урлагийн холбогдох байгууллагуудын мэргэжилтэн албан хаагч нарт соёлын биет бус өвийн талаар орон нутгийн хэмжээнд арга зүйн зөвлөгөө өгөх, уулзалт семинар зохион байгуулах зайлшгүй шаардлагатай байна.

Мөн 2010 оны төсөвт тус хэлтсийн үйл ажиллагааны зардал тусгагдаагүй, тэрчлэн манайд байгаа соёлын биет бус өвийг бүртгэн баримтжуулах зориулалт бүхий техник хэрэгслийн их зонхи нь 7-10 жил ашиглагдаж, эдүгээ нэгэнт хоцрогдож, элэгдсэн зэрэг шалтгааны улмаас уг хэлтсийн өдөр тутмын ажлыг хэвийн хэмжээнд явуулах, энэ чиглэлээр бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэхэд бодит бэрхшээл учирч байгаа төдийгүй хэвийн үйл ажиллагаа явуулахад хүндрэл учруулж байна.

#### **Цаашид авах арга хэмжээний санал:**

- Музейн үзмэрийн судалгаа шинжилгээний ажлыг хөгжүүлэх, дэмжих ялангуяа орон нутагт эрдэм шинжилгээний ажилтнуудын орон тоог зохих ёсоор нь ажиллуулах, музейн ажилтнуудыг мэргэшүүлэх, чадваржуулахад БСШУЯам болон холбогдох газрууд анхаарах хэрэгтэй байна.
- Музейд зөвхөн түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдолтой эд өлгийн зүйлсийг авдаг байх зарчмыг баримтлахад БСШУЯамнаас үзмэрийн чанарын шаардлага хангахгүй, ач холбогдолгүй, хуурамч, дууриамал эд зүйлсийг цуглуулахаас сэргийлж музейн үзмэр худалдан авч байгаа одоогийн тогтолцоог өөрчлөх бодлого боловсруулан хэрэгжүүлэх,
- Биет бус өвийг бүртгэн баримтжуулах, хамгаалах, дуу, дүрс бичлэгийн техникээр хангах зэрэг үйл ажиллагааны зардлыг 2010, 2011 онуудад төсөв хүргүүлсэн ч огт төсөв батлагдаж ирэхгүй байгааг анхаарах
- Биет бус соёлын өвийг хамгаалах Үндэсний хөтөлбөрийг дэмжих, 2011 онд Засгийн газраар батлуулах, хөтөлбөрийг 2012 оноос хэрэгжүүлж эхлэхийг дэмжих
- Өвлөн уламжлагчийн жагсаалтанд орсон иргэдэд гэрчилгээ олгох, урамшуулал олгох ажлыг БСШУЯам хамтран хийх хэрэгтэй байна.
- Сэргээн засварлах үйл ажиллагаанд шаардлагатай байгаа тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг улсын төсөв болон гадаадын хандивлагчдын дэмжлэгээр ойрын хугацаанд шийдвэрлэх,
- Сэргээн засварлах ажилд байнга ашигладаг зарим нэр төрлийн хэрэгцээт материалууд нь дотоодын зах зээлд байдаггүй, гадаад зах зээлээс худалдан

авахад өнөөгийн төсөв нь туйлын бага тул сэргээн засварлах ажлын материал худалдан авах төсвийг нэмэгдүүлэх

- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөрийн хүрээнд Дорнод аймгийн нутаг дэвсгэрт орших Их бурхант, Хэрлэн барс хотын цамхаг дурсгалт газар БНХАУ-ын Соёлын өвийн академийн хамт сэргээн засварлалт, консервацын ажлыг эхлүүлэх санал санаачилгыг дэмжин, Соёлын буцалтгүй тусламжийн хүрээнд уаг ажиллагааг эхлүүлэхэд БСШУЯамнаас дэмжлэг үзүүлэх
- Соёлын өвийн төвийн шинэ зориулалтын барилгад зориулан зураг төслийн төсвийг баталгаажуулах, 2011 оны 7 дугаар сард БСШУ-ны сайд барилгын шав тавих ажлыг зохион байгуулахад бэлтгэх хэрэгтэй байна.

---o0o---